



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ADB
ASIAN
DEVELOPMENT
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

БАГА БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

МОНГОЛ ХЭЛ

АНХДУГААР ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР 2021



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ASIAN
DEVELOPMENT
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨБ

БАГА БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

МОНГОЛ ХЭЛ

АНХДУГААР ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР 2021

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Эрх зүйн баримт бичгүүд	7
Боловсролын үнэлгээ	17

БАГА БОЛОВСРОЛЫН ТҮВШИН МОНГОЛ ХЭЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. I АНГИ

1.1. I ангийн сурагчийн хүрэх суралцахуйн үр дүн	22
1.2. Үнэлгээний нэгж	22

Үсэг бичигт эхлэн суралцах үе

1.2.1. Үнэлгээний нэгж 1. Сонсож ойлгосноо харуулах	22
1.2.2. Үнэлгээний нэгж 2. Унших арга барил эзэмших	23
1.2.3. Үнэлгээний нэгж 3. Бичих арга барил эзэмших	24
1.2.4. Үнэлгээний нэгж 4. Алдаагүй бичихэд суралцах	24

Цагаан толгойн дараах үе

1.2.5. Үнэлгээний нэгж 5. Уншаад ойлгох, уран унших	25
1.2.6. Үнэлгээний нэгж 6 өгүүлбэр, эх зохиож бичих	27

ХОЁРДУГААР БҮЛЭГ. II АНГИ

2.1. II ангийн үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	29
2.2. Үнэлгээний нэгж.	29
2.2.1. Үнэлгээний нэгж 1. Уншсанаа ойлгох	29
2.2.2. Үнэлгээний нэгж 2. Ойлгож, уран унших	31
2.2.3. Үнэлгээний нэгж 3. Уншсанаа бүтээлчээр ойлгох	31
2.2.4. Үнэлгээний нэгж 4. Зөв бичих	32
2.2.5. Үнэлгээний нэгж 5. Зохион найруулж бичих	33
2.2.6. Үнэлгээний нэгж 6. Сонсож ойлгосноо илэрхийлэх	36

ГУРАВДУГААР БҮЛЭГ. III АНГИ

3.1. III ангийн үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	37
3.2. Үнэлгээний нэгж.	37
3.2.1. Үнэлгээний нэгж 1. Уншсанаа ойлгох	37
3.2.2. Үнэлгээний нэгж 2. Ойлгож, уран унших	38
3.2.3. Үнэлгээний нэгж 3. Уншсанаа бүтээлчээр ойлгох	39
3.2.4. Үнэлгээний нэгж 4. Зөв бичих	40
3.2.5. Үнэлгээний нэгж 5. Зохион найруулж бичих	41
3.2.6. Үнэлгээний нэгж 6. Сонсож ойлгосноо илэрхийлэх	43

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. IV АНГИ

4.1. IV ангийн үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	44
4.2. Үнэлгээний нэгж	44
4.2.1. Үнэлгээний нэгж 1. Уншсанаа ойлгох	44
4.2.2. Үнэлгээний нэгж 2. Ойлгож, уран унших.....	46
4.2.3. Үнэлгээний нэгж 3. Уншсанаа бүтээлчээр ойлгох	46
4.2.4. Үнэлгээний нэгж 4. Зөв бичих	47
4.2.5. Үнэлгээний нэгж 5. Зохион найруулж бичих	48
4.2.6. Үнэлгээний нэгж 6. Бусдыг хүндэтгэн сонсох, яриагаа төлөвлөн илэрхийлэх.....	51

ТАВДУГААР БҮЛЭГ. V АНГИ

5.1. V ангийн сурагчийн хүрэх суралцахуйн үр дүн.....	52
5.2. Үнэлгээний нэгж	52
5.2.1. Үнэлгээний нэгж 1. Уншсанаа ойлгох	52
5.2.2. Үнэлгээний нэгж 2. Уншсанаа бүтээлчээр ойлгох	54
5.2.3. Үнэлгээний нэгж 3. Зөв бичих	55
5.2.4. Үнэлгээний нэгж 4. Зохион найруулж бичих	56
5.2.5. Үнэлгээний нэгж 5. Бусдыг ойлгон сонсох, санаа бодлоо илэрхийлэн харилцах.....	59



МЭНДЧИЛГЭЭ

**Эрхэм баян-эрдэм мэдлэгийг түгээн
дэлгэрүүлэгч эрдэмтэн багш нар аа!**

Хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй өнөөгийн нийгэмд зохицон амьдрах хувь хүний эрэлтийг нийгмийн хэрэгцээтэй уялдуулан хөгжүүлэхэд дэлхийн улс орнууд ихээхэн анхаарч, боловсролын тогтолцоогоо улам бүр боловсронгуй болгож байна.

Сургалтын хөтөлбөрт суралцагчийн суралцах чадварын хөгжил, шинжлэх ухааны мэдлэг, ойлголтын эзэмшилт, аливаа зүйлийг судлах сонирхол, идэвх зүтгэлд гарч буй ахиц амжилтыг үнэлэхээр үнэлгээний зорилтыг тодорхойлсон бөгөөд суралцагчийн үнэлгээний журамд “үнэлгээ нь шалгуурт суурилсан” байхаар заасан.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Шалгуур үзүүлэлт батлах тухай” А/180 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, анги, хичээл бүрээр сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд нийцүүлэн боловсруулж, баталлаа.

Энэхүү шалгуур үзүүлэлт батлагдсанаар суралцагчийн ахиц амжилтыг ижил шалгуураар үнэлэх /суралцагчдын ялгаатай байдлыг тодорхойлох/, хичээлийн бэлтгэлийг чанартай хангах /ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, ээлжит хичээлийн төлөвлөлт хийх/ зэрэг багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн хамтын ажиллагааг сайжруулах, эргэх холбоотой ажиллах боломж бүрдэх юм.

Оюунлаг, чадварлаг, бүтээлч шинэ эриний “Монгол хүн” бүтээх гол цөм, тулах цэг нь болсон багш, боловсролын ажилтан та бүхэнд эрүүл энх, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөе.

Энэхүү гарын авлагыг боловсруулахад оролцсон эрдэмтэн багш, судлаач нар болон техникийн дэмжлэг үзүүлсэн Азийн Хөгжлийн банкны “Эдийн засгийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”, Дэлхийн банкны “Бага боловсролын шинэчлэл” төслийн хамт олонд талархал илэрхийлье.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

Лувсанцэрэнгийн ЭНХ-АМГАЛАН

Боловсрол, шинжлэх ухааны сайд



МЭНДЧИЛГЭЭ

Боловсролын үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох үйлсэд оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулан ажиллаж байгаа эрдэмтэн багш, боловсролын ажилтан, судлаачид та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Суралцагчдад хаана, ямар орчинд суралцаж байгаагаас үл хамааран ижил шалгуур, ижил арга, аргачлалаар сурлагын амжилт, ахицаа бодитой тодорхойлуулах хэрэгцээ ямагт байдаг. Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийг бодитой, шинжлэх ухаанчаар үнэлж дүгнэн үнэлгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд үр нөлөөтэйгээр хэрэглэх нь манай орны төдийгүй дэлхийн улс орнуудын багш нарт ч сорилт хэвээр байна.

2018 онд БСШУС-ын (хуучнаар) сайдын А/425 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-д суралцагчийн үнэлгээг шалгуурт суурилсан бөгөөд суралцагчийн сурах хүсэл эрмэлзэл, сурлагын ахиц, амжилтыг дэмжиж, тэднийг хөгжүүлэхэд чиглэсэн байхаар тодорхойлсон нь дээрх хэрэгцээ, шаардлагыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн.

Үнэлгээний шалгуур нь хичээл, сургалтын үр дүнд суралцагчийн юу мэддэг, юу чаддаг, яаж хийж хэрэглэх ёстойг тодорхойлж өгсөн суралцахуй, багшлахуйн ач холбогдолтой “үнэлгээний гол хэрэгсэл” юм. Багш та үнэлгээний шалгуурыг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэснээр суралцагчийн гүйцэтгэлд тулгуурлан сурлагын амжилт, ахиц, өөрчлөлтийн талаар бодитой, үр нөлөөтэй үнэлэлт, дүгнэлт хийж тэдэнд ямар дэмжлэг, хэрхэн үзүүлэхээ тодорхойлох бүрэн боломж бүрдэнэ.

Боловсролын үнэлгээний төв нь хичээл тус бүрээр эрдэмтэн, багш, судлаачдын баг бүрдүүлэн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, судлагдахуун бүрээр үнэлгээний ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖИЙН түвшинд анх удаагаа боловсруулж та бүхний гар дээр хүргэж байна.

Үнэлгээний шалгуурыг олон улсын түвшинд боловсролын үнэлгээ, тэр дундаа суралцагчийн үнэлгээ, үнэлгээний шалгуур чиглэлээр баримталж буй онол, үзэл баримтлалд тулгуурлан өөрийн орны сургалтын хөтөлбөр, багшлахуй, суралцахуйн онцлогийг харгалзан боловсруулсан.

Боловсролын үнэлгээний тогтолцоог сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулах эрхэм багш та бүхний үйлс нь улам өөдөө байж, боловсролын хөгжлийн төлөө сэтгэл, зүтгэл нэгдэн урагшилна гэдэгт итгэл дүүрэн байгаагаа илэрхийлье.

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

Лхагвасүрэнгийн ГАНБАТ
Захирал

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ТУШААЛ

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
~~2018~~ оны ~~02~~ сарын ~~23~~-ны
өдрийн ~~3967~~ дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/425

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3 дахь хэсэг, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар бүлгийн 3.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ыг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн өмчийн бүх хэлбэрийн бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагад мөрдсүгэй.

3. Энэхүү журмыг албан бус сургалтын дүйцсэн хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчдыг үнэлэхэд баримталсугай.

4. Энэхүү тушаалаар батлагдсан журмын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/, Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/, нийслэлийн Боловсролын газар, аймгуудын Боловсрол, соёл, урлагийн газарт тус тус даалгасугай.

5. Журмыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүр улсын төсөвт тусгаж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Х.Галсанхүү/, Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/-д тус тус үүрэг болгосугай.

6. Журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2013 оны “Журам, загвар шинэчлэн батлах тухай” А/309 дүгээр тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон чанарын үнэлгээний журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД




Ц.ЦОГЗОЛМАА

0001553

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын
2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн
А/425 дугаар тушаалын хавсралт



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧИЙН БОЛОН
СУРГАЛТЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн мэдлэг, чадварын ахиц амжилт, үр дүн, төлөвшлийг үнэлж, дүгнэх, хөндлөнгийн хяналт, чанарын үнэлгээ хийхэд энэхүү журмыг баримтална.

1.2. Суралцагчийн үнэлгээ нь сурлагын ахиц, амжилтыг үнэлж, сургалтын арга хэлбэр, зохион байгуулалтад тохируулга хийх; анги дэвших болон сургууль төгсөх шалгалт /цаашид "улсын шалгалт" гэх/ нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлж, сургуулийн үйл ажиллагаа, багшийн арга зүй, ур чадварыг сайжруулах; чанарын үнэлгээ нь боловсролын чанар, үр дүнг тодорхойлж, бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгоход тус тус чиглэнэ.

Хоёр. Үнэлгээнд баримтлах зарчим

2.1. Үнэлгээ нь шударга, бодитой, хөндлөнгийн нөлөөллөөс ангид, шалгуурт суурилсан, суралцагчийн сурах хүсэл эрмэлзэл, сонирхол, ур чадвар, ахиц, амжилтыг дэмжсэн, урамшуулах, хөгжүүлэхэд чиглэсэн байх;

2.2. Үнэлж дүгнэх үйл ажиллагаа нь зорилготой, сургалтын хөтөлбөрт нийцсэн, суралцагчийн нас, сэтгэхүй, хөгжлийн ялгаатай байдал, онцлог хэрэгцээг харгалзсан, агуулга, хэлбэр нь уян хатан, багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчид ойлгомжтой, нээлттэй, ил тод байх;

2.3. Анги дэвших болон улсын шалгалтын сэдэв, даалгавар нь танин мэдэхүйн түвшинд нийцсэн, тохирц, найдварыг шалгасан, нууцлалыг хадгалсан, шалгуулагчдыг хүндэтгэсэн, найдвартай байх.

Гурав. Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээ

3.1. Суралцагчийн үнэлгээ нь тэдний эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, төлөвшил, хандлагын өөрчлөлтийг тооцох, сургууль, багшийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх, сургалтын чанар, үр дүнг сайжруулахад чиглэнэ.

3.2. Суралцагчийн үнэлгээ нь оношлох, явцын, үр дүнгийн гэсэн төрөлтэй байх бөгөөд үнэлгээ нь шалгуурт суурилсан байна.

3.3. "Шалгуурт суурилсан үнэлгээ" нь суралцагчийн амжилтын түвшинг хүрэх үр дүнтэй харьцуулан үнэлэхэд чиглэнэ.

3.4. Хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, анги, хичээл бүрээр боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага хамтран боловсруулж, батална.

3.5. Оношлох үнэлгээ нь хичээлийн жилийн эхэнд эсвэл нэгж хичээл, бүлэг сэдэв эхлэхийн өмнө суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг тандах зорилгоор хийх үнэлгээ байна. Оношлох үнэлгээг ажиглалт, ярилцлага, хэлэлцүүлэг, асуулт, сорил, судалгаа гэх мэт хэлбэрээр хийнэ.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

3.6. Явцын үнэлгээ нь суралцахуйг дэмжих, сайжруулах зорилгоор хичээл, сургалтын явцад тогтмол хийх үнэлгээ байна.

3.7. Явцын үнэлгээг хичээлийн явцад суралцагчийн суралцах үйлийг дэмжихэд чиглэсэн ажиглалт, асуулт, ярилцлага, хэлэлцүүлэг, бие даах ажил, рубрик, суралцагчийн өөрийн болон бусад суралцагчийн үнэлгээ гэх мэт арга, хэлбэрээр багш хийнэ. Явцын үнэлгээг сургалтын баримт бичиг /багшийн журнал/-т стандарт бус тэмдэглэгээгээр тэмдэглэж болно.

3.8. Үр дүнгийн үнэлгээг сурлагын амжилтын үр дүнг хэмжих зорилгоор бүлэг сэдвийн төгсгөл болон хагас жил /II улирлын төгсгөл/, хичээлийн жилийн эцэс /IV улирлын төгсгөл/-т хийнэ. Анги дэвших, улсын шалгалт нь үр дүнгийн үнэлгээ байна.

3.9. Үр дүнгийн үнэлгээг аман болон бичгийн шалгалт, сорил, туршилт, судалгааны ажил, тайлан, төсөлт ажил, илтгэл, эссэ, бүтээл, биечлэн хийж гүйцэтгэх зэрэг хэлбэрээр хийнэ.

3.10. Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн ахиц амжилт, өөрчлөлтийг үнэлэхэд I, II ангид оношлох болон явцын үнэлгээ, III-XII ангид оношлох, явцын, үр дүнгийн үнэлгээний төрлийг ашиглана.

3.11. Үр дүнгийн үнэлгээ нь тухайн хичээл, судлагдахууны агуулгын хүрээнд дараах 8 түвшинтэй байна.

Түвшин	Үнэлгээ, хувиар	Үнэлгээний түвшний шалгуур
VIII	90-100	- Шинжлэх ухааны юмс үзэгдэл, нэр томьёо, ухагдахуун, хууль зарчим, зүй тогтлыг бүрэн ойлгож, шинжлэх ухааны үг хэллэг ашиглан аливаа асуудлыг тайлбарлах, тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөх, санал гаргах түвшинд эзэмшсэн - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах ямар ч нөхцөлд хэрэглэдэг - Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлэн шинжлэн судлах үйлээ төлөвлөдөг - Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах оновчтой аргыг сонгон хэрэглэдэг - Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргадаг, түүнийгээ шинжлэх ухааны үүднээс оновчтой илэрхийлдэг
VII	80-89	- Шинжлэх ухааны юмс үзэгдэл, нэр томьёо, ухагдахуун, зарчим, хууль, зүй тогтол, хоорондын хамаарлыг ойлгож эзэмшсэн - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил бус нарийн төвөгтэй нөхцөлд хэрэглэдэг - Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлэн шинжлэн судлах үйлээ төлөвлөдөг - Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах оновчтой аргыг сонгодог - Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргадаг, түүнийгээ оновчтой илэрхийлдэг
VI	70-79	- Шинжлэх ухааны юмс үзэгдэл, нэр томьёо, ухагдахуун, зарчим, хууль зүй тогтлыг ойлгосон - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил төвөгтэй нөхцөлд хэрэглэдэг - Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлж, шинжлэн судлах үйлийг зааврын дагуу төлөвлөдөг - Асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг боловсруулах тохирох аргыг сонгон хэрэглэдэг - Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргадаг
V	60-69	- Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун, зарчим, хуулийг ойлгосон - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо шинэ нөхцөлд зааврын дагуу хэрэглэдэг - Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлж, шинжлэн судлах, төлөвлөхөд оролцдог - Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах тохирох аргыг сонгодог - Асуудал, мэдээллийг эргэцүүлэн бодож, гол санааг илэрхийлдэг
IV	50-59	- Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун, зарчмыг бүрэн ойлгосон. - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил нөхцөлд хэрэглэдэг - Асуулт асуух, асуудал таамаглал дэвшүүлж, шинжлэн судлах үйлд оролцдог. - Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах аргыг сонгон хэрэглэхийг хичээдэг. - Асуудал, мэдээллийг эргэцүүлэн бодож, санал бодлоо энгийн байдлаар илэрхийлдэг

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ**

III	40-49	• Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун, зарчмыг ойлгох, тайлбарлах түвшинд эзэмшсэн • Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил, хялбар нөхцөлд хэрэглэдэг • Бусдын дэмжлэгтэй, зааврын дагуу хялбар асуудлыг шийдвэрлэдэг • Асуулт асууж, таамаглал дэвшүүлдэг
II	30-39	• Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахууныг таних, нэрлэх, цээжлэх түвшинд эзэмшсэн • Эзэмшсэн мэдлэг ойлголтоо заавар, аргачлалын дагуу ашигладаг
I	0-29	• Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахууныг таних, нэрлэх түвшинд эзэмшсэн

3.12. I-II ангид суралцагчийн тухайн хичээлийн жилд хүрсэн үр дүнг явцын үнэлгээнд үндэслэн анги удирдсан багш дүгнэн хувийн хэрэгт бичиж, эцэг эх, асран хамгаалагчид танилцуулна.

3.13. III-XII ангийн суралцагчийг бүлэг сэдвийн төгсгөлд, хичээлийн жилийн II, IV улирлын эцэст тус тус багш үнэлнэ. Энэхүү үнэлгээний үр дүн /хувь/-г ангийн журналд тэмдэглэнэ. IV улирлын эцэст хийсэн үнэлгээ /хувь/ нь жилийн эцсийн дүн байна.

3.14. III-XII ангийн жилийн эцсийн дүн болон анги дэвших, улсын шалгалтын дүнг ангийн журнал, суралцагчийн хувийн хэрэгт анги удирдсан багш тус тус тэмдэглэнэ.

3.15. Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийг тухайн төлөвлөгөө, хөтөлбөрт нийцсэн шалгуураар үнэлнэ. Шалгуурыг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага хамтран боловсруулна.

3.16. Хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийг явцын үнэлгээгээр үнэлнэ. Суралцагчийн анги дэвших, сургууль төгсөх асуудлыг явцын үнэлгээнд үндэслэн, энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс шийдвэрлэнэ.

3.17. Ерөнхий боловсролын сургууль, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага багшид зөвлөн туслах зорилгоор суралцагчийн мэдлэг, чадварын түвшинд хөндлөнгийн үнэлгээ, хяналт-шинжилгээ хийж болно. Энэхүү үнэлгээ, хяналт-шинжилгээ нь тухайн байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан байна.

3.18. Суралцагчийн төлөвшилийг хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажилд оролцсон байдал, идэвх санаачилгын талаарх хичээл заадаг болон анги удирдсан багшийн тэмдэглэл, баримт нотолгоонд үндэслэн дараах чиглэлээр дүгнэж, суралцагчийн хувийн хэрэгт бичнэ.

- санал бодлоо илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, зөрчил, маргааныг эв зүйгээр шийдвэрлэх байдал;
- бие даан сурах арга барил, бусадтай хамтран ажиллах;
- шинжлэн судлах хүсэл эрмэлзэл, сонирхол, оролцоо;
- соёл, уламжлалаа дээдлэх, асуудал шийдвэрлэх чадвар, бүтээлч, ажил хэрэгч байдал;
- хувийн болон орчны эрүүл ахуй, аюулгүй амьдрах, байгальтай харьцах, хамгаалах, нийгмийн харилцаанд оролцох хандлагад гарч буй өөрчлөлт;
- шинэ орчин, харилцаанд дасан зохицох чадварт гарч буй өөрчлөлт.

3.19. Анги удирдсан багш суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшилийн үнэлгээний талаарх дүгнэлт, саналыг хичээлийн жилийн II, IV улирлын эцэст эцэг эх, асран хамгаалагчид танилцуулна.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

3.20. Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээний мэдээлэл нууцлалтай байх бөгөөд энэхүү мэдээлэлтэй багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч цахим болон бусад хэлбэрээр танилцах боломжийг сургууль бүрдүүлнэ.

Дөрөв. Анги дэвших шалгалт, түүний зохион байгуулалт

4.1. Анги дэвших шалгалт нь суралцагчийн мэдлэг, чадвар эзэмшилтийн түвшинг тогтооход чиглэнэ.

4.2. Сургууль нь энэхүү журмын 3.4-т заасан байгууллагаас баталсан шалгуурын дагуу дараах чиглэлээр журмын 3.9-д заасан хэлбэрээс сонгож анги дэвших шалгалтыг зохион байгуулна.

Боловсролын түвшин	Анги	Шалгалтын тоо	Шалгалтын чиглэл
Бага боловсрол	III	1	Нэгдмэл агуулга /III ангийн хөтөлбөрийн агуулгаар/
	IV	2	- Сургууль сонгох 1 хичээл - Нэгдмэл агуулга /шалгалттай хичээлээс бусад/
Суурь боловсрол	VI	2	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Сургууль сонгох 1 хичээл
	VII	3	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Сургууль сонгох 1 хичээл /шалгалтгүй хичээлээс/
	VIII	3	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Суралцагч сонгох 1 хичээл /шалгалтгүй хичээлээс/
Бүрэн дунд боловсрол	X	3	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Суралцагч сонгох 1 хичээл /хими, биологи, физик, газарзүй, нийгмийн ухаан, түүх, англи хэл, орос хэл хичээлээс/
	XI	3	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Сонгох хичээл /хими, биологи, физик, газарзүй, нийгэм судлал, түүх, англи хэл, орос хэл хичээлээс/

4.4. Журмын 3.4-т заасан байгууллагаас баталсан шалгуур болон “Анги дэвших шалгалтын бюпринт” /цаашид бюпринт гэх/, шалгалт зохион байгуулах нэгдсэн удирдамж, шалгалтын үр дүнд шинжилгээ хийх маягт, зөвлөмжийг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага жил бүрийн 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор ерөнхий боловсролын сургуульд хүргүүлнэ.

4.5. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь ерөнхий боловсролын сургуулийн анги бүрийн сургалтын хөтөлбөрт нийцсэн “Даалгаврын нээлттэй сан” бүрдүүлж, өмчийн бүх хэлбэрийн сургуульд хүргэх, түүнийг хэрэглэх арга зүйгээр хангах ажлыг хичээлийн жилийн турш зохион байгуулна.

4.6. Анги дэвших болон улсын шалгалт зохион байгуулах ажлыг сургуулийн захирлын тушаалаар томилогдсон “Шалгалтын комисс” зохион байгуулна. Комиссын дарга нь сургуулийн захирал байх бөгөөд сургалтын менежер, багш, суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчийн төлөөллийг оролцуулна. Комиссын гишүүн эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл шалгалтын сэдэв, даалгавар боловсруулахад оролцохгүй.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

4.7. Энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.7.1. анги дэвших шалгалт зохион байгуулах удирдамж, дэг боловсруулж, хэрэгжүүлэх;

4.7.2. анги дэвших шалгалттай холбогдон гарсан аливаа гомдол, маргааныг эцэслэн шийдвэрлэх;

4.7.3. шалгалтын үнэлгээ, дүн мэдээг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагаас өгсөн зөвлөмж, маягтын дагуу нэгтгэн, шалгалт зохион байгуулж дууссанаас хойш 10 хоногийн дотор боловсролын салбарын мэдээллийн системд оруулах ажлыг удирдамжаар хангах, хяналт тавих.

4.8. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь анги дэвших шалгалтын үр дүнд шинжилгээ хийж, сургууль бүрд зөвлөмж боловсруулж, жил бүрийн 8 дугаар сарын 25-ны өдрийн дотор хүргүүлнэ.

4.9. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь анги дэвших шалгалтын дүнд үндэслэн зөвлөн туслах ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

4.10. Сургууль энэхүү журмын 4.8-д заасан зөвлөмжид үндэслэн сургалтын үйл ажиллагааг төлөвлөн явуулна.

Тав. Улсын шалгалт, түүний зохион байгуулалт

5.1. Улсын шалгалт нь бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, сурлагын амжилтад хөндлөнгийн үнэлгээ, хяналт-шинжилгээ хийхэд чиглэнэ.

5.2. Улсын шалгалтын үр дүн нь бага, дунд боловсролын сургалтын үр ашиг тооцох, сурлагын амжилтыг сайжруулах суурь мэдээлэл болно.

5.3. Бага, суурь бүрэн дунд боловсролын түвшний төгсөх ангийн суралцагч дараах хичээлээр улсын шалгалт өгнө.

Боловсролын түвшин	Анги	Шалгалтын тоо	Шалгалтын агуулга
Бага боловсрол	V	3	1. Монгол хэл 2. Математик 3. Хүн ба байгаль
Суурь Боловсрол	IX	4	1. Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ 2. Математик 3. Сонгох шалгалт: /суралцагч аль нэгийг сонгоно./ • Байгалийн ухааны нэгдмэл агуулга • Нийгмийн ухаан, түүх /нэгдмэл агуулга/ 4. Гадаадхэл /англи хэл, орос хэл-аль нэгийг суралцагч сонгоно/
Бүрэн дунд боловсрол	XII	4	1. Монголхэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ 2. Математик 3. Сонгох шалгалт /хими, биологи, физик, газарзүй, нийгмийн ухаан, түүх аль нэгийг сонгоно/ 4. Гадаад хэл /англи, орос хэл-аль нэгийг суралцагч сонгоно/

5.4. Улсын шалгалтын товыг боловсролын үнэлгээний байгууллагаас жил бүр тогтоох бөгөөд шалгалтыг улсын хэмжээнд зэрэг эхлүүлж, дуусгана.

5.5. Улсын шалгалтын үнэлгээг энэхүү журмын 3.11-д заасан үнэлгээгээр үнэлнэ.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

5.7.Боловсролын үнэлгээний байгууллага нь "Улсын шалгалтын бюлпринт" /цаашид бюлпринт" гэх/, шалгалтын сэдэв боловсруулах, дүгнэх зөвлөмжийг жил бүрийн 5 дугаар сарын 15- ны өдрийн дотор баталгаажуулж, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад хүргүүлнэ.

5.8.Боловсролын үнэлгээний байгууллага нь бага, суурь, бүрэн дунд боловсролын анги бүрийн сургалтын хөтөлбөрт нийцсэн "Даалгаврын нээлттэй сан" /цаашид "даалгаврын сан" гэх/ бүрдүүлэх, шинэчлэх, баяжуулалт хийх ажлыг хариуцна.

5.9.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь "Улсын шалгалтын комисс"- ыг жил бүрийн 5 дугаар сарын 01 -ний өдрийн дотор байгуулна. Энэхүү комисс нь тухайн орон нутагт улсын шалгалт зохион байгуулах ажлыг удирдлага, арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллана.

5.10. Сургууль дээр улсын шалгалт зохион байгуулахтай холбогдуулан энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.10.1.улсын шалгалтын удирдамж, дэгийг боловсруулж, шалгалтыг зохион байгуулах;

5.10.2.шалгалт эхлэхээс 1 өдрийн өмнө энэхүү журмын 5.7-д заасан бюлпринт, зөвлөмжийн дагуу улсын шалгалтын сэдэв боловсруулж, нууцлалыг хариуцах;

5.10.3.шалгалтын дүн мэдээг боловсролын салбарын мэдээллийн системд оруулах ажлыг удирдан зохион байгуулж, хяналт тавих;

5.10.4.хөгжлийн бэрхшээлтэй суралцагч шалгалт өгөх тохиолдолд тэдний хөгжлийн онцлог, хэрэгцээнд тохирсон шалгалтын орчин бүрдүүлэх;

5.10.5.улсын шалгалттай холбогдон гарсан аливаа маргааныг эцэслэн шийдвэрлэх;

5.10.6.шалгалтын материал, тайланг сургуулийн архивт хүлээлгэн өгөх.

5.11.Шалгалт зохион байгуулах хугацаанд улсын болон олон улсын уралдаан, тэмцээнд оролцсон суралцагчийн улсын шалгалтын үнэлгээг нотлох баримтад үндэслэн жилийн эцсийн үнэлгээгээр тооцно.

5.12.Суралцагч өвчлөх, ар гэрийн гачигдал тохиолдох болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас шалгалт өгөөгүй эсвэл дутуу өгсөн тохиолдолд улсын шалгалтын үнэлгээг жилийн эцсийн үнэлгээгээр тооцож болно.

5.13.Боловсролын үнэлгээний байгууллага нь боловсролын салбарын мэдээллийн системд оруулсан улсын шалгалтын дүнд шинжилгээ хийж, жил бүрийн 10 дугаар сард багтаан, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагад тус тус хүргүүлнэ.

5.14.Журмын 5.9-д заасан "Улсын шалгалтын комисс" нь улсын шалгалт зохион байгуулсан тайланг нэгтгэн, шалгалт дууссанаас хойш 10 хоногийн дотор боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Зургаа. Чанарын үнэлгээ, түүний зохион байгуулалт

6.1.Бага, дунд боловсролын чанарын үнэлгээ нь суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг үндэсний түвшинд тогтоох, сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлийг судлах, боловсролын бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд чиглэнэ.

6.2.Чанарын үнэлгээг боловсролын үнэлгээний байгууллага зохион байгуулна.

6.3.Чанарын үнэлгээнд өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн нийт суралцагчийн 10-аас доошгүй хувийг хамруулна.

6.4.Боловсролын үнэлгээний байгууллага нь чанарын үнэлгээ зохион байгуулах товыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтооно.

6.5.Чанарын үнэлгээг зохион байгуулах агуулгын хүрээ, шалгуурыг боловсролын үнэлгээний байгууллага, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага хамтран жил бүрийн 01 дүгээр сард багтаан тогтооно.

6.6.Боловсролын үнэлгээний байгууллага нь чанарын үнэлгээг зохион байгуулах удирдамж, аргачлалыг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар баталгаажуулна.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

6.7.Боловсролын үнэлгээний байгууллага нь чанарын үнэлгээний өгөгдлийн сан үүсгэх, дүн шинжилгээ хийж, тайлан, санал, дүгнэлтийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад тус тус хүргүүлнэ.

6.8.Чанарын үнэлгээний үр дүнд үндэслэн энэхүү журмын 6.7-д заасан байгууллага бодлого боловсруулах, зөвлөн туслах ажлыг зохион байгуулна.

6.9.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага чанарын үнэлгээний тайланд үндэслэн сурлагын амжилтыг сайжруулах төлөвлөгөө гаргаж ажиллана.

6.10.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь чанарын үнэлгээг зохион байгуулахад бүх талын дэмжлэг үзүүлж ажиллана.

Долоо. Бусад

7.1.Аливаа төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийг үнэлэх, шалгалт зохион байгуулахыг хориглоно.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН А/180 ТУШААЛ



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/180

Улаанбаатар хот

Шалгуур үзүүлэлт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 28.1.8 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/425 дугаар тушаалаар батлагдсан "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам"-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хавсралтаар баталсугай.

2. Суралцагчийн хичээл, сургалтын үр дүнг энэхүү тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур"-ыг баримтлан 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн үнэлсүгэй.

3. Шалгуурын дагуу үнэлгээ хийх арга зүйн зөвлөмжийг боловсруулж, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтныг арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Бага, дунд боловсролын газар /Т.Ням-Очир/, Боловсролын үнэлгээний төв /Л.Ганбат/, аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Д.Батбаатарт даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

142110643

СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ (*Student assessment*)

Сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, тэдэнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц;

ШАЛГУУР (*Criteria*)

Зорилт, стандартын биелэлтийг тодорхойлоход ашигладаг жишиг үзүүлэлт эсвэл түвшин;
(UNESCO-CEPES, 2007)

ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР (*Assessment criteria*)

Суралцахуйн үр дүнд хүрэхэд шаардлагатай тодорхой мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлдог.

ОНОШЛОХ ҮНЭЛГЭЭ (*Diagnostic assessment*)

Хичээл, сургалтын эхэнд суралцагчдын өмнөх мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийг тандах зорилгоор хийгдэх үнэлгээ;

ЯВЦЫН ҮНЭЛГЭЭ (*Formative assessment*)

Багш, суралцагчийн зүгээс суралцагчийн “суралцахуй”-г танин мэдэх, хариу үйлдэл үзүүлэх зорилгоор сургалтын явц /ээлжит хичээл/-д хийгдэх үнэлгээ;

ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ (*Summative assessment*)

Хичээл, сургалт /нэгж, хагас жил, жилийн эцэст г.м тодорхой хугацааны/-ын дараа үнэлгээний шалгуурт хүрсэн байдлыг тогтоож, цаашид суралцахуй болон багшлахуйд анхаарах зүйлийг тодорхойлох зорилгоор хийгдэх үнэлгээ;

СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго¹/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх²/, үнэлж дүгнэх³ зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшилийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ “шалгуур”-т суурилсан байна.

ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд “үнэлгээ”-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

1 Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

2 Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариултыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

3 Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад⁴ нийцсэн байна. Үүнд:


- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



⁴ Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс" судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.



БАГА БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

МОНГОЛ ХЭЛ

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Нэгдүгээр бүлэг - I анги

Хоёрдугаар бүлэг - II анги

Гуравдугаар бүлэг - III анги

Дөрөвдүгээр бүлэг - IV анги

Тавдугаар бүлэг - V анги

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. I АНГИ

1.1. I АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Сурагч үсэг, бичигт эхлэн тайлагдах, эх хэлээрээ зөв ярьж, бие биеэ хүндэтгэлтэй сонсох, бүтээлчээр уншиж бичих чадвар эзэмшиж, эх хэлээ сонирхон судлах хүсэл эрмэлзэлтэй болно.

1.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ

ҮСЭГ БИЧИГТ ЭХЛЭН СУРАЛЦАХ ҮЕ

1.2.1. Үнэлгээний нэгж 1. Сонсож ойлгосноо харуулах

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
0.1а. Бусдын уншсан үлгэр, өгүүллэгийг сонсож, асуултад хариулах 0.1б. Сурах бичиг дэх зургийн дагуу үлгэр өгүүллэгийг ярих 1.3а. Өгсөн зургийг ажиглаж үйл явдлыг тод, чанга, ойлгомжтой ярих 1.3б. Бусдын яриа, асуулт, зааврыг анхааралтай сонсож, ойлгосноо харуулах	Сурагч бусдын яриа, асуулт, заавар, үлгэр, өгүүллэг зэргийг сонсож ойлгосноо харуулж чаддаг болно.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Сурагч бусдын яриа, асуулт, заавар, үлгэр, өгүүллэг зэргийг сонсож ойлгосноо харуулж чаддаг болно.	Үлгэр, өгүүллэг зэргийг анхааралтай сонсож, утгыг ойлгосноо зургийн дагуу үйл явдлыг тоочиж ярьдаг. Бусдын яриа, асуулт, заавар, үлгэр, өгүүллэг зэргийг анхааралтай сонсож, ойлгосноо ойлгомжтой ярьж, илэрхийлдэг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Үлгэр, өгүүллэг зэргийг анхааралтай сонсож, утгыг ойлгосноо зургийн дагуу үйл явдлыг тоочиж ярьдаг.	Бусдын ярьсан үлгэр, өгүүллэг зэргээс утгыг ойлгосноо зураг харж ерөнхийд нь нэрлэж ярьдаг.	Бусдын ярьсан үлгэр, өгүүллэг зэргээс ойлгосноо эхлээд?, дараа нь?, эцэст нь? гэсэн асуултын чиглүүлгээр тоочиж ярьдаг.	Үлгэр, өгүүллэг зэргийг анхааралтай сонссон боловч зарим үйл явдлыг орхигдуулан ойлгомжтой ярьдаг	Үлгэр, өгүүллэг зэргийг анхааралтай сонсож, утгыг ойлгосноо зургийн дагуу үйл явдлыг орхигдуулалгүй тоочиж ярьдаг.
Бусдын яриа, асуулт, заавар, үлгэр, өгүүллэг зэргийг анхааралтай сонсож ойлгосноо ойлгомжтой ярьж, илэрхийлдэг.	Бусдын яриа, асуулт, зааврыг бүрэн ойлгодоггүй.	Бусдын яриа, асуулт, зааврыг дутуу ойлгож, бусдын дэмжлэгтэй ойлгосноо илэрхийлдэг.	Бусдын яриа, асуулт, зааврыг ойлгосон ч дутуу илэрхийлдэг	Бусдын яриа, асуулт, заавар, үлгэр, өгүүллэг зэргийг анхааралтай сонсож ойлгосноо ойлгомжтой ярьж, илэрхийлдэг.

1.2.2. Үнэлгээний нэгж 2. Унших арга барил эзэмших

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
0.2а. Үгийн бүтцээс богино, урт, хос эгшиг үсгийг ялган таних, нэрлэх, зөв унших (а, аа, ай, э, ээ, эй, и, ий, ы, о, оо, ой, ө, өө, у, уу, уй, ү, үү, үй) 0.2б. Дармал ба бичмэл “м, с, х, р, в, л, н, ш” үсгийг таних, нэрлэх, задгай ба битүү үеийг нүдлэх, үг, холбоо үгийг үелж зөв унших 0.2в. Дармал ба бичмэл б, г, д, т, ц, ч, з, ж үсгийг таних, нэрлэх, задгай ба битүү үеийг нүдлэх, 1-2 үетэй үгийг шууд, урт үг, холбоо үгийг үелж зөв унших 0.2г. Зөөлний тэмдгийг ялган таних, нэрлэх, зөөлөрсөн гийгүүлэгч бүхий үсгийг зөв унших 0.2д. “я, е, ё, ю” болон “к, п, ф, ц” үсгийг ялган таних, нэрлэх, эдгээр үсэг бүхий үг, холбоо үг, хялбар эхийг унших, 2-3 үетэй үгийг шууд унших 0.2е. Хатуугийн тэмдгийг ялган таних, нэрлэх, үг унших 0.4а. Өгсөн үгээс эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсгийг таньж нэрлэх	Сурагч үеийг шууд уншиж, үг, холбоо үг, өгүүлбэр, эхийг шууд уншиж ойлгож чаддаг болно.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Сурагч үеийг шууд уншиж, үг, холбоо үг, өгүүлбэр, эхийг шууд уншиж ойлгож чаддаг болно.	Цагаан толгойн авиаг ялган сонсож, зөв дуудан, үсгийн нэрийг зөв хэлдэг. Хатуу, зөөлний тэмдгийг эхээс ялган таньж, зөв нэрлэдэг. Өгүүлбэр, эхийг үг үгээр зааглан уншиж утгыг ойлгодог. Үг, холбоо үг, өгүүлбэр, танил эхийг шууд уншиж, утгыг ойлгож чаддаг болно.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Цагаан толгойн авиаг ялган сонсож, зөв дуудан, үсгийн нэрийг зөв хэлдэг. Хатуу, зөөлний тэмдгийг эхээс ялган таньж, зөв нэрлэдэг.	Цагаан толгойн авиа үсгийг ялган нэрлэж, авиаг үгийн эхэн, адагт ялган сонсож, авиаг солихгүй зөв дууддаг.	Цагаан толгойн авиа үсгийг дарааллаар нь зөв дуудан, зарим үсгийн нэрийг нэрлэж, дүрс ойролцоо үсгүүдийн авиаг хааяа сольж дууддаг.	Цагаан толгойн эгшиг, гийгүүлэгч авиаг ялган зөв дуудан, зарим үсгийн нэрийг нэрлэж, дүрс ойролцоо үсгүүдийг ялгаж зөв дууддаг.	Цагаан толгойн авиаг ялган сонсож, зөв дуудан, үсгийн нэрийг зөв хэлдэг болсон байна. Хатуу, зөөлний тэмдгийг үгээс ялган таньж, зөв нэрлэж чаддаг.
Өгүүлбэр, эхийг үг үгээр зааглан уншиж утгыг ойлгодог. Үг, холбоо үг, өгүүлбэр, танил эхийг шууд уншиж, утгыг ерөнхийд нь ойлгодог.	Эх дэх үг, холбоо үгийг уншиж, зарим үгийн утгыг ойлгодог.	Өгүүлбэр, эхийг холбоо үгээр зааглан уншиж утгыг ерөнхийд нь ойлгодог. Зарим богино үгийг үелж уншин, утгыг ойлгодог.	Өгүүлбэр, эхийг үг үгээр зааглан уншиж, утгыг ерөнхийд нь ойлгодог. Зарим урт үгийг үелэн, холбоо үгийг шууд уншиж, утгыг ойлгодог.	Өгүүлбэр, эхийг үг үгээр зааглан шууд уншиж утгыг ерөнхийд нь ойлгодог. Үг, холбоо үгийг шууд уншиж, утгыг ойлгодог.

1.2.3. Үнэлгээний нэгж 3. Бичих арга барил эзэмших

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
0.3а. Үсэг бүтээдэг зурлагуудыг дэвтрийн шугамаар баримжаалан дэгийн дагуу бичих	Цагаан толгойн үсгийн үндсэн зурлага, том, жижиг үсгийг дэгийн дагуу бичиж чаддаг болно.
0.3б. Богино, урт, хос эгшиг үсгийг дэгийн дагуу бичих (а, аа, ай, э, ээ, эй, и, ий, ы, о, оо, ой, ө, өө, у, уу, уй, ү, үү, үй)	
0.3в. Том, жижиг “м, с, х, р, в, л, н, ш” үсгийг дэгийн дагуу бичих, зөв холбон бичих	
0.3г. Том, жижиг “б, г, д, т, ц, ч, з, ж” үсэг болон зөөлний тэмдгийг дэгийн дагуу бичих, зөв холбон бичих	
0.3д. Том, жижиг “я, е, ё, ю” болон “к, п, ф, щ” үсэг, хатуугийн тэмдгийг дэгийн дагуу бичих, үг, холбоо үг, өгүүлбэрийг бичих	
0.3е. Хуулж бичихдээ урт үгийг үеэр, богино үгийг бүтнээр нүдэлж бичих	

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Цагаан толгойн үсгийн үндсэн зурлага, том, жижиг үсгийг дэгийн дагуу бичиж чаддаг болно.	Цагаан толгойн үсгийн дэвтрийн шугамыг баримжаалан үсгийн хэмжээ, налууг, чиглэлийг тохируулан зөв холбон бичдэг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Цагаан толгойн үсгийн дэвтрийн шугамыг баримжаалан үсгийн хэмжээ, налууг, чиглэлийг тохируулан зөв холбон бичдэг.	Ихэнх үсгийг дэвтрийн шугамыг баримжаалан хэмжээ, налуу, чиглэлийг жигд, үсгүүдийг зөв холбон бичдэг.	Зарим үсгийг хэмжээ, налуу, чиглэлийг жигд, цөөн үсгийг буруу холбон бичдэг.	Үсгийг хэмжээ, налуу, чиглэлийг жигд бус, хэд хэдэн үсгийн холболтыг буруу бичдэг.	Цагаан толгойн үсгийн дэвтрийн шугамыг баримжаалан үсгийн хэмжээ, налууг, чиглэлийг тохируулан зөв холбон бичдэг

1.2.4. Үнэлгээний нэгж 4. Алдаагүй бичихэд суралцах

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
0.4б. Хуулж болон цээжээр бичихдээ хүний нэр ба өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичих	Сурагч хуулж болон цээжээр бичихдээ том үсгийн дүрмийн дагуу зөв бичиж чаддаг болно.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Сурагч хуулж болон цээжээр бичихдээ том үсгийн дүрмийн дагуу зөв бичиж чаддаг болно.	Сурагч танил бус үгээс бүтсэн 2-4 өгүүлбэрийг хуулж, танил үгээс бүтсэн 2-4 өгүүлбэрийг цээжээр бичихдээ том үсгийн дүрмийг хэрэглэн зөв бичдэг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч танил бус үгээс бүтсэн 2-4 өгүүлбэрийг хуулж, танил үгээс бүтсэн 2-4 өгүүлбэрийг цээжээр бичихдээ том үсгийн дүрмийг хэрэглэн зөв бичиж чаддаг болно.	Сурагч танил бус үгээс бүтсэн 2-4 өгүүлбэрийн зарим үгийг алдаагүй зөв хуулж бичихдээ том үсгийн дүрмийг хэрэглэн бичдэг.	Сурагч танил бус үгээс бүтсэн 2-4 өгүүлбэрийн зарим үгийг алдаагүй хуулж, танил үгээс бүтсэн 1-2 өгүүлбэрийг эхлэхдээ том үсгийн дүрмийг хэрэглэн цээжээр бичдэг.	Сурагч танил бус үгээс бүтсэн 2-4 өгүүлбэрийг алдаагүй зөв хуулж, танил үгээс бүтсэн 2-3 өгүүлбэрийг цээжээр бичихдээ том үсгийн дүрмийг хэрэглэн зөв бичдэг.	Сурагч танил бус үгээс бүтсэн 2-4 өгүүлбэрийг алдаагүй зөв хуулж, танил үгээс бүтсэн 2-4 өгүүлбэрийг цээжээр бичихдээ том үсгийн дүрмийг хэрэглэн зөв бичдэг.

ЦАГААН ТОЛГОЙН ДАРААХ ҮЕ

1.2.5. Үнэлгээний нэгж 5. Уншаад ойлгох, уран унших

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1.1а. Өгүүлбэр, эхээс танил биш үгийг олж, утгыг нь таамаглах	Сурагч хялбар эхийн утгыг ойлгож уншихдаа тоочих, төсөөлөх замаар эхийн агуулгыг ерөнхийд нь ойлгож чаддаг болно.
1.1б. Сурах бичгийн эх, зурагт эх, богино хэмжээтэй хялбар эхийг уншиж агуулгыг ерөнхийд нь ойлгосноо харуулах	
1.1в. Уншсан эхийн үйл явдлыг асуултын дагуу тоочин ярих (эхлээд? дараа нь, эцэст нь?)	Өгүүлбэр, эх уншихдаа танил биш үгийг ялган тэмдэглэж унших арга барилтай болно.
1.1г. Уншсан эхийн баатрын хийсэн зүйлийг тоочих	Сурагч цээжилсэн бэлгэ дэмбэрлийн үг, хэл зүгшрүүлэх үгийг тод, чанга, шүлгийг бусдын өмнө уран, тод чанга дуугаар уншдаг болно.
1.1д. Цээжилсэн хэл зүгшрүүлэх үг, бэлгэ дэмбэрлийн үг, шүлгийг бусдын өмнө тод чанга дуугаар унших	
1.1е. Зохиолын баатруудын гадаад байдлыг төсөөлж ярих	

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Шалгуур
Сурагч хялбар эхийн утгыг ойлгож уншихдаа тоочих, төсөөлөх замаар эхийн агуулгыг ерөнхийд нь ойлгож чаддаг болно.	Өгүүлбэр, эх уншихдаа танил биш үгийг ялган тэмдэглэж, ойр орчмын үг, өгүүлбэрийн утгаас таамаглан уншдаг
	Уншсан эхийн үйл явдлыг дарааллаар нь бие даан бүрэн гүйцэд, асуултын дагуу ярьдаг, баатрын хийсэн үйлийг гүйцэд тоочин ярьдаг.
	Баатрын гадаад дүр байдлыг (харц, хөдөлгөөн, дохио зангаа, гадаад төрх) өөрийнхөөрөө ургуулан бодож төсөөлөн, ойлгомжтой, тод, чанга илэрхийлэн ярьдаг
Сурагч цээжилсэн бэлгэ дэмбэрлийн үг, хэл зүгшрүүлэх үгийг тод, чанга, шүлгийг бусдын өмнө уран, тод чанга дуугаар уншдаг болно.	10 хэл зүгшрүүлэх үг, 10 бэлгэ дэмбэрлийн үгийг бүрэн цээжлэн тод, чанга, сард 1 шүлгийн утгыг ойлгон уншиж, зогсоц, өргөлтийг тааруулан бусдын өмнө уран, тод чанга дуугаар уншдаг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Өгүүлбэр, эх уншихдаа танил биш үгийг ялган тэмдэглэж, ойр орчмын үг, өгүүлбэрийн утгаас таамаглан уншдаг	Өгүүлбэр, эх уншихдаа багшийн дэмжлэгтэйгээр танил биш үгийг ялгадаг.	Өгүүлбэр, эх уншихдаа танил биш үгийг ялган тэмдэглэдэг.	Өгүүлбэр, эх уншихдаа танил биш үгийг ялган тэмдэглэж, өөрийнхөөрөө таамаглан уншдаг.	Өгүүлбэр, эх уншихдаа танил биш үгийг ялган тэмдэглэж, ойр орчмын үг, өгүүлбэрийн утгаас таамаглан уншдаг.
Сурагч хялбар эхийн утгыг ойлгож уншихдаа тоочих, төсөөлөх замаар эхийн агуулгыг ерөнхийд нь ойлгодог.	Уншсан эхийн үйл явдал болон баатрын хийсэн үйлийн ихэнх хэсгийг орхигдуулан ярьдаг.	Уншсан эхийн үйл явдал болон баатрын хийсэн үйлийн зарим хэсгийг орхигдуулан тогтоосон хэсгээ ярьдаг.	Уншсан эхийн үйл явдлыг болон баатрын хийсэн үйлдлийг дарааллын дагуу бусдын дэмжлэгтэй ярьдаг.	Уншсан эхийн үйл явдлыг дарааллаар нь бие даан бүрэн гүйцэд, асуултын дагуу ярьдаг, баатрын хийсэн үйлийг гүйцэд тоочин ярьдаг.
Баатрын гадаад дүр байдлыг (харц, хөдөлгөөн, дохио зангаа, гадаад төрх) өөрийнхөөрөө ургуулан бодож төсөөлөн, ойлгомжтой, тод, чанга илэрхийлэн ярьдаг.	Баатрын гадаад дүр байдлыг (гадаад төрх) өөрийнхөөрөө ургуулан бодож төсөөлөн, ойлгомжтой илэрхийлдэг.	Баатрын гадаад дүр байдлыг (хөдөлгөөн, гадаад төрх) өөрийнхөөрөө ургуулан бодож төсөөлөн, ойлгомжтой илэрхийлдэг.	Баатрын гадаад дүр байдлыг (харц, хөдөлгөөн, дохио зангаа, гадаад төрх) өөрийнхөөрөө ургуулан бодож төсөөлөн, ойлгомжтой илэрхийлэн ярьдаг.	Баатрын гадаад дүр байдлыг (харц, хөдөлгөөн, дохио зангаа, гадаад төрх) өөрийнхөөрөө ургуулан бодож төсөөлөн, ойлгомжтой, тод, чанга илэрхийлэн ярьдаг.
10, 10 хэл зүгшрүүлэх үг, бэлгэ дэмбэрлийн үгийг бүрэн цээжлэн тод, чанга, сард 1 шүлгийн утгыг ойлгон уншиж, зогсоц, өргөлтийг тааруулан бусдын өмнө уран, тод чанга дуугаар уншдаг.	8-9 хэл зүгшрүүлэх үг, бэлгэ дэмбэрлийн үгийг зарим хэсгийг цээжлэн, сард 1 шүлгийн зарим хэсгийг цээжлэн, бусдын өмнө сул дуугаар уншдаг.	8-9 хэл зүгшрүүлэх үг, бэлгэ дэмбэрлийн үгийг бүрэн цээжлэн, сул дуугаар уншдаг, сард 1 шүлгийн утгыг ойлгон бусдын өмнө тод чанга дуугаар уншдаг.	8-9 хэл зүгшрүүлэх үг, бэлгэ дэмбэрлийн үгийг бүрэн цээжлэн тод, чанга, сард 1 шүлгийн утгыг ойлгон уншиж, зогсоц, өргөлтийг тааруулан бусдын өмнө уран, тод чанга дуугаар уншдаг.	10, 10 хэл зүгшрүүлэх үг, бэлгэ дэмбэрлийн үгийг бүрэн цээжлэн тод, чанга, сард 1 шүлгийн утгыг ойлгон уншиж, зогсоц, өргөлтийг тааруулан бусдын өмнө уран, тод чанга дуугаар уншдаг.

1.2.6. Үнэлгээний нэгж 6 өгүүлбэр, эх зохиож бичих

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1.2а. Хуулж болон цээжээр бичихдээ үг, үсэг, өгүүлбэрийг дэгийн дагуу бичих	Сурагч хуулж болон цээжээр бичихдээ том үсэг, цэг цэглэлийн дүрмийн дагуу зөв бичиж чаддаг болно.
1.2б. Хүний нэр ба өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичих, өгүүлбэрт цэг, таслал, асуултын тэмдгийг зөв хэрэглэх	
1.2в. Зураг, бүдүүвчид тохирсон 3-4 үгтэй өгүүлбэр зохиож бичих	
1.2г. Багшийн хэлсэн 2-4 үгээс бүтсэн өгүүлбэрийг сонсож, цээжээр бичих	Сурагч загвар, асуулт, зураг, бүдүүвчийн дагуу 3-4 өгүүлбэр бүхий эх зохион бичиж чаддаг болно.
1.2д. Өгсөн загвар, асуулт, зургийн дагуу 3-4 өгүүлбэр бүхий зохиож бичих	
1.2е. Өөрийгөө 4-5 өгүүлбэрээр танилцуулж бичих	Сурагч өөрийгөө 4-5 өгүүлбэрээр танилцуулж бичиж чаддаг болно.
0.4в. Өгүүлбэрийг хаана? хэзээ? гэсэн асуултаар дэлгэрүүлэх	

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Сурагч хуулж болон цээжээр бичихдээ том үсэг, цэг цэглэлийн дүрмийн дагуу зөв бичиж чаддаг болно.	Сурагч танил үгээс бүтсэн 2-4 өгүүлбэрийг цээжээр бичихдээ том үсэг, цэг, таслал, асуултын тэмдгийг зөв хэрэглэн бичдэг
Сурагч загвар, асуулт, зураг, бүдүүвчийн дагуу 3-4 өгүүлбэр бүхий эх зохион бичиж чаддаг болно.	Өгсөн загвар, асуулт, зураг, бүдүүвчид тохирсон утгын уялдаа холбоотой 3-4 өгүүлбэр бүхий эхийг хэн?, юу?, яав?, хаана?, хэзээ? гэсэн асуултаар дэлгэрүүлэн алдаагүй зөв зохиож бичдэг.
Сурагч өөрийгөө 4-5 өгүүлбэрээр танилцуулж бичиж чаддаг болно.	Өөрийнхөө тухай 4-5 өгүүлбэрээр танилцуулж, ойлгомжтой, алдаагүй зөв бичдэг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч танил үгээс бүтсэн 2-4 өгүүлбэрийг цээжээр бичихдээ том үсэг, цэг, таслал, асуултын тэмдгийг зөв хэрэглэн бичдэг.	Сурагч эхийг хуулж бичихдээ том үсэг, цэг, таслал, асуултын тэмдгийг зөв бичиж чаддаг.	Сурагч танил үгээс бүтсэн 2-3 өгүүлбэрийг цээжээр бичиж чаддаг.	Сурагч танил үгээс бүтсэн 2-4 өгүүлбэрийг цээжээр бичихдээ том үсгийн дүрмийг зөв хэрэглэн бичдэг.	Сурагч танил үгээс бүтсэн 2-4 өгүүлбэрийг цээжээр бичихдээ том үсэг, цэг, таслал, асуултын тэмдгийг зөв хэрэглэн бичдэг.

Өгсөн загвар, асуулт, зураг, бүдүүвчид тохирсон утгын уялдаа холбоотой 3-4 өгүүлбэр бүхий эхийг хэн?, юу?, яав?, хаана?, хэзээ? гэсэн асуултаар дэлгэрүүлэн алдаагүй зөв зохиож бичдэг.	Өгсөн загвар, асуулт, зураг, бүдүүвчид тохирсон утгын уялдаа холбоотой 2-3 өгүүлбэр бүхий эхийг хэн?, юу?, яав?, хаана?, хэзээ? гэсэн асуултаар дэлгэрүүлэн зарим үгийг алдаатай бичдэг.	Өгсөн загвар, асуулт, зураг, бүдүүвчид тохирсон 2-3 өгүүлбэр бүхий эхийг багшийн дэмжлэгтэй хэн?, юу?, яав?, хаана?, хэзээ? гэсэн асуултаар дэлгэрүүлэн зарим тохиолдолд танил үгийн хүрээнд алдаагүй зөв зохиож бичдэг.	Өгсөн загвар, асуулт, зураг, бүдүүвчид тохирсон утгын уялдаа холбоотой 3-4 өгүүлбэр бүхий эхийг багшийн дэмжлэгтэй хэн?, юу?, яав?, хаана?, хэзээ? гэсэн асуултаар дэлгэрүүлэн алдаагүй зөв зохиож бичдэг.	Өгсөн загвар, асуулт, зураг, бүдүүвчид тохирсон утгын уялдаа холбоотой 3-4 өгүүлбэр бүхий эхийг хэн?, юу?, яав?, хаана?, хэзээ? гэсэн асуултаар дэлгэрүүлэн алдаагүй зөв зохиож бичдэг.
Өөрийнхөө тухай 4-5 өгүүлбэрээр танилцуулж, ойлгомжтой, алдаагүй зөв бичдэг.	Өөрийнхөө тухай асуулт, загварын дагуу 2-3 өгүүлбэрээр танилцуулж, зарим үгийг алдаатай бичдэг.	Өөрийнхөө тухай асуултын дагуу танил үгийн хүрээнд 3-4 өгүүлбэрээр танилцуулж, зарим үгийг алдаатай бичдэг.	Өөрийнхөө тухай асуултын дагуу танил үгийн хүрээнд 4-5 өгүүлбэрээр танилцуулж ойлгомжтой, алдаагүй зөв бичдэг.	Өөрийнхөө тухай 4-5 өгүүлбэрээр танилцуулж, ойлгомжтой, алдаагүй зөв бичдэг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. II АНГИ

2.1. II АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Сурагч нь “зөв, хурдан, ойлгож” унших, уран унших, уншсанаа тоочих, тайлбарлах, төсөөлөх, таамаглах, мөн өгөгдсөн бүтэц, зааврын дагуу санаа бодлоо тусган зохион найруулан бичихдээ зөв бичгийн дүрмийг баримтлах, бусдыг анхааралтай сонсох, эх хэлээрээ зөв, тод чанга, ойлгомжтой ярих чадвар эзэмшиж, хэл соёлоо хүндэтгэдэг иргэн төлөвшүүлнэ.

2.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ

2.2.1. Үнэлгээний нэгж 1. Уншсанаа ойлгох

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
2.1б. Уншсан шүлэг, өгүүллэг, үлгэр, зүйр цэцэн үг, хэл зүгшрүүлэх үг зэрэг эхийг уншиж, агуулгыг ерөнхийд нь ойлгосноо харуулах	Сурагч эхийн утгыг ойлгож, зөв хурдан уншаад, уншсан зүйлээ тоочиж, тайлбарлаж чаддаг болно.
2.1в. Уншсан үлгэр, өгүүллэгийг үйл явдлын дарааллын дагуу тоочих	
2.1г. Уншсан эхийн баатруудын сайн, муу үйлийг жишээгээр тайлбарлах	
2.1д. Талархал, мэндчилгээ, товч анкет, танилцуулга, заавар зэргийг уншиж, агуулга, бүтцийг тайлбарлах	

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Сурагч эхийн утгыг ойлгож, зөв хурдан уншаад, уншсан зүйлээ тоочиж, тайлбарлаж чаддаг болно.	97-100%-ийн гүйцэтгэлтэй буюу “чадварлаг” түвшинд зөв, хурдан уншиж, агуулгыг ерөнхийд нь бүрэн ойлгож чаддаг
	Эхийн агуулгыг уншиж ойлгосны үндсэн дээр үйл явдлыг дарааллын дагуу тоочиж чаддаг.
	Уншсан эхийн баатруудын сайн, муу үйлийг эхээс оновчтой жишээ татаж тайлбарладаг.
	Талархал, мэндчилгээ, товч анкет, танилцуулга, зааврыг уншиж агуулгыг бүрэн ойлгон агуулга, бүтцийг тайлбарладаг

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
97-100%-ийн гүйцэтгэлтэй буюу “чадварлаг” түвшинд зөв, хурдан уншиж, агуулгыг ерөнхийд нь ойлгож чаддаг (2.1б)	90-ээс доош %-ийн гүйцэтгэлтэй буюу “хангалтгүй” түвшинд зарим үгийг үсэглэн, үгийн авиа, үеийг буруу дуудан, эсвэл сольж хурдан уншиж, нийт агуулгын 70%-ийг ойлгож уншдаг	90-96%-ийн гүйцэтгэлтэй буюу “хангалттай” түвшинд зарим үгийг үечилж, үгийн авиа, үеийг буруу дуудан, эсвэл сольж, хурдан уншиж, нийт агуулгын 80%-ийг ойлгож уншдаг	90-96%-ийн гүйцэтгэлтэй буюу “хангалттай” түвшинд бүтэн үгээр, авиа, үеийг сольж, гээлгүй зөв, хурдан уншиж, агуулгыг бүрэн ойлгож уншдаг	97-100%-ийн гүйцэтгэлтэй буюу “чадварлаг” түвшинд бүтэн үгээр, авиа, үеийг сольж, гээлгүй зөв, хурдан уншиж, агуулгыг бүрэн ойлгож уншдаг

Эхийн агуулгыг уншиж ойлгосны үндсэн дээр үйл явдлыг дарааллын дагуу тоочиж чаддаг. (2.1в)	Уншсан эхийн үйл явдлын дарааллыг алдагдуулж тоочдог.	Эхийн агуулгыг уншиж ойлгосны үндсэн дээр үйл явдлыг багшийн чиглүүлсэн “эхлээд, дараа нь, эцэст нь хэн?, юу?, яав?” зэрэг асуултын дагуу дараалан тоочдог.	Эхийн агуулгыг уншиж ойлгосны үндсэн дээр эхлэл, гол, төгсгөл гэсэн бүтцийн хүрээнд үйл явдлыг дараалан тоочдог.	Эхийн агуулгыг уншиж ойлгосны үндсэн дээр үйл явдлыг дарааллын дагуу ойлгомжтой тоочдог.
Уншсан эхийн баатруудын сайн, муу үйлийг эхээс оновчтой жишээ татаж тайлбарладаг. (2.1г)	Уншсан эхийн баатруудын сайн, муу үйлийг эхээс тоочдог.	Уншсан эхийн баатруудын сайн, муу үйлийг ямар учраас, яагаад гэсэн асуултын дагуу жишээ татаж тайлбарладаг.	Уншсан эхийн баатруудын сайн, муу үйлийг эргэцүүлэн бодож эхээс жишээ татаж тайлбарладаг.	Уншсан эхийн баатруудын сайн, муу үйлийг эхээс оновчтой жишээ татаж, яагаад сайн, муу үйл гэж үзэж байгаагаа ойлгомжтойгоор тайлбарладаг
Эхийг уншиж агуулгыг бүрэн ойлгон агуулга, бүтцийг тайлбарладаг. (2.1д)	Эхийг уншиж агуулгыг ойлгохдоо эхлэл, гол, төгсгөл хэсгийг асуултаар зааглан тоочиж нэрлэдэг.	Эхийг уншиж ойлгохдоо эхлэл, гол, төгсгөл хэсгийг асуултаар зааглан утгыг ерөнхийд нь өөрийн үгээр тайлбарладаг.	Эхийг уншиж агуулгыг ойлгохдоо эхлэл, гол, төгсгөл хэсгийг зааглан бичигчийн зорилгыг ойлгож тайлбарладаг.	Эхийг уншиж агуулгыг ойлгохдоо эхлэл, гол, төгсгөл хэсгийг зөв зааглан бүтэц тус бүрд зорилго агуулгыг оновчтой тайлбарладаг.

Тайлбар:

1. Агуулгыг бүрэн ойлгоно гэдэг нь эхийн утгыг ойлгосныг шалгах зорилготой багшийн асуултад оновчтой, зөв хариулсныг хамааруулж ойлгоно.
2. “97-100%-ийн гүйцэтгэлтэй буюу “чадварлаг” түвшинд зөв, хурдан уншиж, агуулгыг ерөнхийд нь ойлгож чаддаг” шалгуурыг боловсруулахдаа БСШУСЯ, Дэлхийн банк, Боловсролын хүрээлэн, “Бага ангийн сурагчдын унших чадварыг үнэлэх, хөгжүүлэх зарим арга хэрэгсэл” (2019)¹ ном дахь аргачлалыг ашигласан болно.
3. “Уншсан эхийн баатруудын сайн, муу үйлийг эхээс оновчтой жишээ татаж тайлбарладаг” гэсэн 3 дахь түвшинд сурагчид сайн, мууг нотлохгүйгээр оновчгүй жишээ татсан байвал энэ түвшинд гүйцэтгэлээ гэж үзнэ. Харин 4 дэх түвшинд сайн, мууг нотлох оновчтой жишээ татах учиртай.

2.2.2. Үнэлгээний нэгж 2. Ойлгож, уран унших

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
2.1е. Цээжилсэн шүлэг, зугаа үг, хэл зүгшрүүлэх үгийг бусдын өмнө тод чанга дуугаар унших	Сурагч зугаа үг, хэл зүгшрүүлэх үгийг бүрэн цээжлэн тод, чанга, цээжилсэн шүлгийг бусдын өмнө уран, тод, чанга дуугаар уншдаг болсон байна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Сурагч цээжилсэн зугаа үг, хэл зүгшрүүлэх үгийг тод, чанга, цээжилсэн шүлгийг бусдын өмнө уран, тод чанга дуугаар уншдаг болсон байна.	1-2 зугаа үг, 15 хэл зүгшрүүлэх үгийг бүрэн цээжлэн, тод, чанга уншдаг, сард 1 шүлгийг бүрэн цээжилж утгыг ойлгосноор зогсоц, өргөлтийг тааруулан бусдын өмнө уран, тод чанга дуугаар уншдаг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1-2 зугаа үг, 10 хэл зүгшрүүлэх үгийг бүрэн цээжлэн, тод, чанга уншдаг, сард 1 шүлгийг бүрэн цээжилж утгыг ойлгосноор зогсоц, өргөлтийг тааруулан бусдын өмнө уран, тод чанга дуугаар уншдаг.	1-2 зугаа үг, 7-8 хэл зүгшрүүлэх үгийн зарим хэсгийг цээжлэн, сул дуугаар уншдаг, сард 1 шүлгийн зарим хэсгийг цээжлэн, бусдын өмнө сул дуугаар уншдаг.	1-2 зугаа үг, 7-8 хэл зүгшрүүлэх үгийг бүрэн цээжлэн, тод, чанга уншдаг, сард 1 шүлгийг бүрэн цээжилж бусдын өмнө тод чанга дуугаар уншдаг.	1-2 зугаа үг, 7-8 хэл зүгшрүүлэх үгийг бүрэн цээжлэн, тод, чанга уншдаг, сард 1 шүлгийг бүрэн цээжилж утгыг ойлгосноор зогсоц, өргөлтийг тааруулан бусдын өмнө уран, тод чанга дуугаар уншдаг.	1-2 зугаа үг, 10 хэл зүгшрүүлэх үгийг бүрэн цээжлэн, тод, чанга уншдаг, сард 1 шүлгийг бүрэн цээжилж утгыг ойлгосноор зогсоц, өргөлтийг тааруулан бусдын өмнө уран, тод чанга дуугаар уншдаг.

2.2.3. Үнэлгээний нэгж 3. Уншсанаа бүтээлчээр ойлгох

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
2.1ж. Өгсөн зургаас баатрууд хоорондоо юу ярилцсаныг ургуулан төсөөлөх	Эхийн агуулгыг ургуулан бодож төсөөлж, таамагладаг болно.
2.1з. Өгсөн зургаас үндэслэн үйл явдлыг таамаглах	

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Эхийн агуулгыг ургуулан бодож төсөөлж, таамагладаг болно.	Эхийн үйл явдлын зургаас баатрууд хоорондоо юу ярилцсаныг өөрийн оюун дүгнэлтээр ургуулан бодож төсөөлдөг.
	Зурган эх, зураг дахь орчин, баатруудын хийсэн үйлдэл, харцнаас үйл явдал цааш хэрхэн үргэлжлэхийг үндэслэлтэй таамагладаг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Эхийн үйл явдлын зургаас баатрууд хоорондоо юу ярилцсаныг өөрийн оюун дүгнэлтээр ургуулан бодож төсөөлдөг. (2.1ж)	Эхийн үйл явдлын зургаас баатрууд хоорондоо юу ярилцсаныг чиглүүлэг асуултын дагуу дүрслэн, ургуулан бодож төсөөлдөг.	Эхийн үйл явдлын зургаас баатрууд хоорондоо юу ярилцсаныг 1-2 өгүүлбэрийн хүрээнд өөрийнхөөрөө төсөөлдөг.	Эхийн үйл явдлын зургаас баатрууд хоорондоо юу ярилцсаныг эргэцүүлэн, 3-4 өгүүлбэрийн хүрээнд төсөөлдөг	Эхийн үйл явдлын зургаас баатрууд хоорондоо юу ярилцсаныг өөрийн оюун дүгнэлтээр ургуулан бодож, 3-4 өгүүлбэрийн хүрээнд төсөөлдөг.
Зурган эх, зураг дахь орчин, баатруудын хийсэн үйлдэл, харцнаас үйл явдал цааш хэрхэн үргэлжлэхийг үндэслэлтэй таамагладаг. (2.1з)	Эхийн үйл явдал харуулсан зургаас цааш хэрхэн үргэлжлэхийг өөрийнхөөрөө ургуулан бодож илэрхийлдэг.	Зурган эх, зураг дахь орчин, баатруудын хийсэн үйлдлээс цааш хэрхэн үргэлжлэхийг чиглүүлэх асуултын тусламжтайгаар үндэслэлтэй таамагладаг.	Зурган эх, зураг дахь орчин, баатруудын хийсэн үйлдлээс цааш хэрхэн үргэлжлэхийг үндэслэлтэй таамагладаг.	Зурган эх, зураг дахь орчин, баатруудын хийсэн үйлдэл, харцнаас үйл явдал цааш хэрхэн үргэлжлэхийг үндэслэлтэй таамагладаг.

2.2.4. Үнэлгээний нэгж 4. Зөв бичих

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
2.2а. н, г үсгээр утга ялгаж үгсийг зөв унших, нүдлэх, зөв бичих 2.2б. Эр, эм үгэнд “ы, ий” залгаврыг зөв залган бичих 2.2в. Үгийг үеэр таслан мөр шилжүүлж зөв бичих 2.2г. Цагаан толгойн үсгийг эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсэг гэж ангилж, бүлэглэх 2.2д. Багшийн хэлсэн 5-6 өгүүлбэрийг сонсож, цээжээр бичих	Зөв бичих дүрмийг мэдэж, зохион найруулж бичихдээ алдаагүй зөв бичиж сурна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Зөв бичих дүрмийг мэдэж, зохион найруулж бичихдээ алдаагүй зөв бичиж сурна.	Утга ялгасан үгийг н,г зөв уншиж, зөв бичдэг.
	Цээжээр бичихдээ эр, эм үгэнд “ы, ий” залгаврыг дүрмийн дагуу алдаагүй зөв залган бичдэг.
	Үгийг дүрмийн дагуу үеэр зөв таслан, мөр шилжүүлж алдаагүй бичиж чаддаг.
	Цагаан толгойн үсгийг эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсгээр зөв ангилж, бүлэглэж чаддаг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Утга ялгасан үгийг [н,г] зөв уншиж, зөв бичдэг (2.2а)	/н,г,х/-г орсон үгийг зөв уншиж, авиаг зөв дуудаж, нэр үг, үйл үгээр нь таньдаг.	Утга ялгасан үгийг /н,г/ зөв уншиж, өгүүлбэрээс утгыг ялган таньдаг.	Утга ялгасан үгийг [н,г] зөв уншиж, утгыг нь тайлбарлаж чаддаг	Утга ялгасан үгийг [н,г] зөв уншиж, холбоо үг зохиож чаддаг.
Цээжээр бичихдээ эр, эм үгэнд “ы, ий” залгаврыг дүрмийн дагуу алдаагүй зөв залган бичдэг. (2.2б)	Эхээс эр, эм үгэнд “ы, ий” залгаврыг залгасан үгийг ялган таньдаг.	Эр, эм үгэнд “ы, ий” залгаврыг залгах дүрмийн зүй тогтлыг жишээн дээр тайлбарлаж чаддаг.	Эр, эм үгэнд “ы, ий” залгаврыг буруу залгасан дүрмийн алдааг таньж засаж чаддаг.	Цээжээр бичихдээ эр, эм үгэнд “ы, ий” залгаврыг дүрмийн дагуу алдаагүй зөв залган бичиж чаддаг.
Үгийг дүрмийн дагуу үеэр зөв таслан, мөр шилжүүлж алдаагүй бичиж чаддаг. (2.2в)	Үгийг үеэр таслан, мөр шилжүүлэх дүрмийг мэддэг.	Үгийг дүрмийн дагуу үеэр зөв таслан мөр шилжүүлэх дүрмийн зүй тогтлыг жишээн дээр тайлбарлаж чаддаг	Үгийг үеэр зөв таслаагүй дүрмийн алдааг таньж засан, мөр шилжүүлж, зөв бичиж чаддаг.	Үгийг дүрмийн дагуу үеэр зөв таслан, мөр шилжүүлэн зөв бичиж чаддаг.
Цагаан толгойн үсгийг эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсгээр зөв ангилж, бүлэглэж чаддаг. (2.2г)	Цагаан толгойн үсгийг эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсгээр ангилж чаддаг.	Зааврын дагуу цагаан толгойн үсгийг эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсгээр зөв ангилж, бүлэглэж чаддаг.	Цагаан толгойн үсгийг эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсгээр зөв ангилж, бүлэглэн алдаатай ангиллыг засаж чаддаг.	Цагаан толгойн үсгийг эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсгээр зөв ангилж, загвар дээр бүлэглэн тайлбарлаж чаддаг.

2.2.5. Үнэлгээний нэгж 5. Зохион найруулж бичих

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
2.2е. Өгсөн бүтцийн дагуу мэндчилгээ бичих 2.2ж. Өгсөн бүтцийн дагуу болсон явдлаа ойлгомжтой бичих 2.2з. Өгсөн бүтэц зааврын дагуу баярлаж талархсанаа илэрхийлсэн талархал бичих 2.2и. Сэдэвт болон цуврал зургийн дагуу утгын холбоотой 4-5 өгүүлбэр бүхий эх зохиох 2.2к. Ертөнцийн гурвын хэлбэрийг дуурайн зохион бичих 2.2л. Зааврын дагуу гэр бүлээ танилцуулж бичих 2.4а. Эх, өгүүлбэрээс хэн? юу? ямар? хэд хэчнээн? яах? яав? яасан? гэсэн асуултад хариулагдах үсгийг олох, эх, өгүүлбэр зохиохдоо зөв хэрэглэх 2.4б. Асуусан, хүүрнэсэн өнгө аястай өгүүлбэр зохиохдоо асуултын тэмдэг, таслал, цэгийг оновчтой хэрэглэх	Сурагч өгөгдсөн бүтэц, зааврын дагуу эх зохиож, найруулан бичиж чаддаг болсон байна. /богино өгүүллэг буюу 4-5 өгүүлбэр бүхий эх, мэндчилгээ, талархал, гэр бүлийн танилцуулга, болсон явдал/

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Сурагч өгөгдсөн бүтэц, зааврын дагуу эх зохиож, найруулан бичиж чаддаг болсон байна. /богино өгүүлэл буюу 4-5 өгүүлбэр бүхий эх, мэндчилгээ, талархал, гэр бүлийн танилцуулга, болсон явдал/	Мэндчилгээний бүтцийн дагуу оновчтой үг сонгон, утгын уялдаа холбоотой, ойлгомжтой, үзсэн зөв бичгийн дүрмийн хүрээнд алдаагүй бичдэг.
	Талархлын бүтцийн дагуу хэнд, юуны учир талархаж байгаагаа утгын уялдаа холбоотой, ойлгомжтой илэрхийлэн, оновчтой үг сонгон, үзсэн зөв бичгийн дүрмийн хүрээнд алдаагүй бичдэг.
	Өгсөн сэдэвт болон цуврал зургийн үйл явдлын дагуу 4-5 өгүүлбэр бүхий эх зохиож бичихдээ асуултын тэмдэг, таслал, цэгийг оновчтой хэрэглэн утгын уялдаатай, үзсэн зөв бичих дүрмийн хүрээнд алдаагүй бичиж чаддаг.
	Өгсөн зааврын дагуу гэр бүлээ танилцуулж бичихдээ ойлгомжтой, үзсэн зөв бичих дүрмийн хүрээнд алдаагүй бичиж чаддаг.
	Өгсөн бүтцийн дагуу болсон явдлаа утгын уялдаа холбоотой, ойлгомжтой, зохион найруулахдаа үзсэн зөв бичих дүрмийн хүрээнд алдаагүй бичиж чаддаг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Мэндчилгээний бүтцийн дагуу утгын уялдаа холбоотой, ойлгомжтой, оновчтой үг сонгон, үзсэн зөв бичгийн дүрмийн хүрээнд алдаагүй бичдэг.	Хэнд, хэзээ, ямар зорилгоор мэндчилж байгаагаа ерөнхийд нь илэрхийлэн бичдэг.	Багшийн өгсөн зааврын дагуу хэнд, ямар зорилгоор мэндчилж байгаагаа бичдэг.	Мэндчилгээний бүтцийн дагуу, оновчтой үг сонгон, үзсэн зөв бичгийн дүрмийн хүрээнд алдаагүй бичдэг.	Мэндчилгээний бүтцийн дагуу утгын уялдаа холбоотой, ойлгомжтой, оновчтой үг сонгон, үзсэн зөв бичгийн дүрмийн хүрээнд алдаагүй бичдэг.
Талархлын бүтцийн дагуу хэнд, юуны учир талархаж байгаагаа утгын уялдаа холбоотой, ойлгомжтой илэрхийлэн, оновчтой үг сонгон, үзсэн зөв бичгийн дүрмийн хүрээнд алдаагүй бичдэг.	Талархал бичихдээ хэнд, юуны учир баярлаж, талархаж байгаагаа ерөнхийд нь илэрхийлэн бичдэг.	Талархал бичихдээ багшийн өгсөн зааврын дагуу талархсан сэтгэлээ ойлгомжтой илэрхийлэн бичдэг.	Талархлын бүтцийн дагуу, оновчтой үг сонгон, үзсэн зөв бичгийн дүрмийн хүрээнд алдаагүй бичдэг.	Талархлын бүтцийн дагуу хэнд, юуны учир талархаж байгаагаа утгын уялдаа холбоотой, ойлгомжтой илэрхийлэн, оновчтой үг сонгон, үзсэн зөв бичгийн дүрмийн хүрээнд алдаагүй бичдэг.

Өгсөн сэдэвт болон цуврал зургийн үйл явдлын дагуу 4-5 өгүүлбэр бүхий эх зохиож бичихдээ асуултын тэмдэг, таслал, цэгийг оновчтой хэрэглэн утгын уялдаатай, үзсэн зөв бичих дүрмийн хүрээнд алдаагүй бичиж чаддаг.	Өгсөн сэдэвт болон цуврал зургийн үйл явдлын дагуу эх зохиохдоо 2-3 өгүүлбэрээр санаагаа тоочиж бичдэг.	Зааврын тусламжтайгаар сэдэвт болон цуврал зургийн үйл явдлын дагуу 2-3 өгүүлбэр бүхий эх зохиож бичихдээ асуултын тэмдэг, таслал, цэгийг зарим үед зөв хэрэглэж чаддаг	Өгсөн сэдэвт болон цуврал зургийн үйл явдлын дагуу 4-5 өгүүлбэр бүхий эх зохиож бичихдээ асуултын тэмдэг, таслал, цэгийг оновчтой хэрэглэн, үзсэн зөв бичих дүрмийн хүрээнд алдаагүй бичиж чаддаг.	Өгсөн сэдэвт болон цуврал зургийн үйл явдлын дагуу 4-5 өгүүлбэр бүхий эх зохиож бичихдээ асуултын тэмдэг, таслал, цэгийг оновчтой хэрэглэн утгын уялдаатай, үзсэн зөв бичих дүрмийн хүрээнд алдаагүй бичиж чаддаг.
Өгсөн зааврын дагуу гэр бүлээ танилцуулж бичихдээ ойлгомжтой, үзсэн зөв бичих дүрмийн хүрээнд алдаагүй бичиж чаддаг.	Өгсөн зааврын дагуу гэр бүлээ танилцуулж бичихдээ асуух үгээр дэлгэрүүлэн, ерөнхийд нь тоочиж бичдэг.	Өгсөн зааврын дагуу гэр бүлээ танилцуулж бичихдээ бэлэн загвар, анкет ашиглан ойлгомжтойгоор бичдэг.	Өгсөн зааврын дагуу гэр бүлээ танилцуулж бичихдээ гол зүйлээ дурдан ойлгомжтойгоор илэрхийлж бичдэг.	Өгсөн зааврын дагуу гэр бүлээ дэлгэрэнгүй танилцуулж бичихдээ ойлгомжтой, үзсэн зөв бичих дүрмийн хүрээнд алдаагүй бичиж чаддаг.
Өгсөн бүтцийн дагуу болсон явдлаа утгын уялдаа холбоотой, ойлгомжтой, зохион найруулахдаа үзсэн зөв бичих дүрмийн хүрээнд алдаагүй бичиж чаддаг.	Өгсөн зааврын дагуу болсон явдлаа бичихдээ ерөнхийд нь тоочиж бичдэг.	Зааврын тусламжтайгаар бүтцийн дагуу болсон явдлаа бичихдээ зарим үгийг зөв бичих дүрмийн алдаатай бичдэг.	Өгсөн бүтцийн болсон явдлаа бичихдээ гол санаагаа ойлгомжтойгоор илэрхийлж бичдэг.	Өгсөн бүтцийн дагуу болсон явдлаа утгын уялдаа холбоотой, ойлгомжтой, зохион найруулахдаа үзсэн зөв бичих дүрмийн хүрээнд алдаагүй бичиж чаддаг.

Тайлбар:

“2.4а. Эх, өгүүлбэрээс хэн? юу? ямар? хэд хэчнээн? яах? яав? яасан? гэсэн асуултад хариулагдах үгсийг олох, эх, өгүүлбэр зохиохдоо зөв хэрэглэх” гэсэн суралцахуйн зорилт буюу чадварыг багш нар ямар ч төрлийн эх зохион бичүүлэх явцад шалгуур болгон хэрэглэнэ.

“2.4б. Асуусан, хүүрнэсэн өнгө аястай өгүүлбэр зохиохдоо асуултын тэмдэг, таслал, цэгийг оновчтой хэрэглэх” гэсэн хэлзүйн ойлголт бүхий суралцахуйн зорилтыг ямар ч эх зохиоход үнэлгээний шалгуур болгон хэрэглэж болно. Хэрэв өмнөх ангид энэ чадварыг эзэмшсэн гэж тооцож байвал дараагийн ангид шалгуур болгон авахгүй байж болно.

2.2.6. Үнэлгээний нэгж 6. Сонсож ойлгосноо илэрхийлэх

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
2.3а. Болсон явдал, сонссон зүйлийг ойлгомжтой мэдээлж ярих 2.3б. Бусдын яриа, асуулт, зааврыг анхааралтай сонсож, ойлгосноо харуулах	Сурагч сонсож ойлгосноо зөв илэрхийлж, бусадтай үр дүнтэй харилцаж сурна.
2.3в. Санаа бодлоо өөртөө итгэлтэйгээр ойлгомжтой, тод дуугаар илэрхийлэх	Сурагч бусдын яриа, асуулт, зааврыг анхааралтай сонсож сурна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Сурагч бусдын яриа, асуулт, зааврыг анхааралтай сонсож сурна.	Бусдын яриа, асуулт, зааврыг анхаарлаа төвлөрүүлэн сонсож чаддаг.
Сурагч сонсож ойлгосноо зөв илэрхийлж, бусадтай үр дүнтэй харилцаж сурна.	Бусдын яриа, асуулт, зааврыг анхааралтай сонсож, ойлгосноо өөртөө итгэлтэйгээр ойлгомжтой, тод дуугаар мэдээлэн ярьж илэрхийлдэг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Бусдын яриа, асуулт, зааврыг анхаарлаа төвлөрүүлэн сонсож чаддаг.	Бусдын яриа, асуулт, зааврыг анхаарлаа төвлөрүүлэхгүй, бусдад саад болон сонсдог.	анхаарал нь үе үе сарнин бусдын яриа, асуулт, зааврыг сонсдог.	Бусдын яриа, асуулт, зааврыг анхаарлаа төвлөрүүлсэн ч зарим зүйлийг ойлгож сонсдог.	Бусдын яриа, асуулт, зааврыг анхаарлаа төвлөрүүлэн сонсож чаддаг.
Бусдын яриа, асуулт, зааврыг анхааралтай сонсож, ойлгосноо өөртөө итгэлтэйгээр ойлгомжтой, тод дуугаар мэдээлэн ярьж илэрхийлдэг.	Бусдын яриа, асуулт, зааврыг анхаарал нь сарнисан ч ерөнхийд нь ойлгосноо өөрийнхөөрөө илэрхийлдэг.	Бусдын яриа, асуулт, зааврыг анхааралтай сонсож, ойлгосноо чиглүүлэгт асуултын дагуу ойлгомжтой, тод дуугаар мэдээлэн ярьж илэрхийлдэг.	Бусдын яриа, асуулт, зааврыг анхааралтай сонсож, ойлгосноо ойлгомжтой, тод дуугаар мэдээлэн ярьж илэрхийлдэг.	Бусдын яриа, асуулт, зааврыг анхааралтай сонсож, ойлгосноо өөртөө итгэлтэйгээр ойлгомжтой, тод дуугаар оновчтой мэдээлэн ярьж илэрхийлдэг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. III АНГИ

3.1. III АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Сурагч нь “зөв, хурдан, ойлгож” унших, уран унших, уншсанаа тоочих, тайлбарлах, ялгах, төсөөлөх, таамаглах, өгөгдсөн бүтэц, зааврын дагуу санаа бодлоо тусган зохион найруулан бичихдээ зөв бичгийн дүрмийг баримтлах, бусдын яриаг идэвхтэй сонсож харилцах, эх хэлээрээ бусдын өмнө тодорхой ярих чадвар эзэмшиж, хэл соёлоо хүндэтгэдэг иргэн болж төлөвшинө.

3.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ

3.2.1. Үнэлгээний нэгж 1. Уншсанаа ойлгох

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
3.1б. Уншсан эх, үлгэр, өгүүллэг, шүлгээс чухал хэсгийг ялгаж, ойлгосноо харуулах	Сурагч эхийн утгыг ойлгож, зөв хурдан уншаад, уншсан зүйлээ тоочиж, тайлбарлаж, ялгаж чаддаг болно.
3.1в. Уншсан үлгэр, өгүүллэг дэх баатрын үйл хөдлөлийн учир шалтгааныг тайлбарлах	
3.1г. Эхээс баатрын болон зохиогчийн үгийг ялгах	
3.1д. Уншсан зохиолын баатруудын зан чанарыг эхээс жишээ татаж тайлбарлах	
3.1е. Талархсан захидал, зорилгодоо хүрэх төлөвлөгөө, номын тэмдэглэл, хаяг, шошго зэргийг уншиж, агуулга, бүтцийг тайлбарлах	

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Сурагч эхийн утгыг ойлгож, зөв хурдан уншаад, уншсан зүйлээ тоочиж, тайлбарлаж чаддаг болно.	97-100%-ийн гүйцэтгэлтэй буюу “чадварлаг” түвшинд бүтэн үгээр, ярианы хурдаар, амьсгалаа тохируулан зөв, хурдан уншиж, агуулгыг бүрэн ойлгодог.
	Уншсан эхийн баатрын үйл хөдлөлийн учир шалтгаан, баатрын зан чанарыг эхээс оновчтой жишээ татан тайлбарладаг.
	Хэрэглээний эх уншиж агуулгыг ойлгохдоо эхлэл, гол, төгсгөл хэсгийг зөв зааглан ямар үг хэрэглэн бичсэнийг оновчтой тайлбарладаг.
	Уншсан эхээс өөртөө чухал гэж үзсэн хэсгийг ялгаж, яагаад чухал гэж үзсэнээ жишээлэн тайлбарлаж ойлгосноо харуулдаг.
	Уншсан эхээс баатрын үг, зохиогчийн үгийг оновчтой ялгадаг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
97-100%-ийн гүйцэтгэлтэй буюу “чадварлаг” түвшинд бүтэн үгээр, ярианы хурдаар, амьсгалаа тохируулан зөв, хурдан уншиж, агуулгыг бүрэн ойлгодог.	90-ээс доош %-ийн гүйцэтгэлтэй буюу “хангалтгүй” түвшинд зарим үгийн авиа, үеийг буруу дуудан, эсвэл сольж, хурдан уншдаг, нийт агуулгын 70%-ийн утгыг ойлгодог.	90-96%-ийн гүйцэтгэлтэй буюу “хангалттай” түвшинд бүтэн үгээр, авиа, үеийг сольж, гээлгүй, ярианы хурдаар уншин, нийт агуулгын 80%-ийн утгыг ойлгодог.	90-96%-ийн гүйцэтгэлтэй буюу “хангалттай” түвшинд бүтэн үгээр, ярианы хурдаар, амьсгалаа тохируулан уншиж, агуулгыг бүрэн ойлгодог.	97-100%-ийн гүйцэтгэлтэй буюу “чадварлаг” түвшинд бүтэн үгээр, ярианы хурдаар, амьсгалаа тохируулан зөв, хурдан уншиж, агуулгыг бүрэн ойлгодог.

Уншсан эхийн баатрын үйл хөдлөлийн учир шалтгаан, баатрын зан чанарыг эхээс оновчтой жишээ татан тайлбарладаг.	Уншсан эхийн баатрын яагаад тэр үйл хөдлөлийг хийх болсон учир шалтгаан болоод баатрын зан чанарыг тоочдог.	Уншсан эхийн баатрын үйл хөдлөлийн учир шалтгаан, зан чанарыг эхээс хийсэн үйл, хэлсэн үгтэй нь холбон тайлбарладаг.	Уншсан эхийн баатрын үйл хөдлөлийн учир шалтгаан, зан чанарыг ингэсэн учраас, үүний тулд гэсэн холбоосын дэмжлэгтэйгээр ямар зан чанар гаргасан гэдгийг жишээ татаж тайлбарладаг.	Уншсан эхийн баатрын үйл хөдлөлийн учир шалтгаан, баатрын зан чанарыг эхээс оновчтой жишээ татан тайлбарладаг.
Хэрэглээний эх уншиж агуулгыг ойлгохдоо эхлэл, гол, төгсгөл хэсгийг зөв зааглан ямар үг хэрэглэн бичсэнийг оновчтой тайлбарладаг.	Хэрэглээний эх уншиж агуулгыг ойлгохдоо эхлэл, гол, төгсгөл хэсгийг өөрийнхөөрөө зааглан тоочдог.	Хэрэглээний эх уншиж агуулгыг ойлгохдоо эхлэл, гол, төгсгөл хэсгийг зааврын дагуу зааглан утгыг ерөнхийд нь өөрийн үгээр тайлбарладаг.	Хэрэглээний эх уншиж агуулгыг ойлгохдоо эхлэл, гол, төгсгөл хэсгийг зөв зааглан утгыг ойлгож тайлбарладаг.	Хэрэглээний эх уншиж агуулгыг ойлгохдоо эхлэл, гол, төгсгөл хэсгийг зөв зааглан ямар үг хэрэглэн бичсэнийг оновчтой тайлбарладаг.
Уншсан эхээс өөртөө чухал гэж үзсэн хэсгийг ялгаж, яагаад чухал гэж үзсэнээ жишээлэн тайлбарлаж ойлгосноо харуулдаг.	Уншсан эхийн үйл явдлыг тоочдог.	Уншсан эхээс өөртөө чухал гэж үзсэн хэсгийг ялгаж, тоочдог.	Уншсан эхээс өөртөө чухал гэж үзсэн хэсгийг ялгаж, яагаад чухал гэж үзсэнээ тайлбарлаж, ойлгосноо харуулдаг.	Уншсан эхээс өөртөө чухал гэж үзсэн хэсгийг ялгаж, яагаад чухал гэж үзсэнээ жишээлэн тайлбарлаж ойлгосноо харуулдаг.
Уншсан эхээс баатрын үг, зохиогчийн үгийг оновчтой ялгадаг.	Уншсан эхээс баатрын зарим үгийг ялгадаг.	Уншсан эхээс баатрын үгийг бүгдийг зөв ялгадаг.	Уншсан эхээс баатрын үгийг бүгдийг болон зохиогчийн үгийг ялгадаг.	Уншсан эхээс баатрын үг, зохиогчийн үгийг оновчтой ялгадаг.

3.2.2. Үнэлгээний нэгж 2. Ойлгож, уран унших

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
3.1а. Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс үсгийн дарааллаар олж, агуулгыг ойлгох	Тайлбар толь бичиг ашиглан танил биш үгийг мэддэг болно.
3.1ж. Цээжилсэн шүлгийн утгыг мэдэрч, мэдрэмжээ илэрхийлэн уран унших	Сурагч шүлэг цээжлэн, үгийн утгаас мэдрэмжээ илэрхийлэн, уран уншдаг болно.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Тайлбар толь бичиг ашиглан танил биш үгийг мэддэг болно.	Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс үсгийн дарааллаар олж агуулгыг ойлгодог.

Сурагч шүлэг цээжлэн, үгийн утгаас мэдрэмжээ илэрхийлэн, уран уншдаг болно.	Цээжилсэн шүлгийн утгыг мэдэрч ойлгосны үндсэн дээр мэдрэмжээ илэрхийлэн, дуу хоолойн өнгө, биеийн хөдөлгөөн, айзам хэмнэл, зогсоц, өргөлт, хурд, нүүрний хувирлаа тохируулан дүрд тоглон, уран уншдаг.
---	---

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс үсгийн дарааллаар олж агуулгыг ойлгодог.	Эхээс танил биш үгийг олж тэмдэглэдэг.	Эх өгүүлбэр уншихдаа танил биш үгийн утгыг ойр орчмын үг, өгүүлбэрийн утгаас таамагладаг.	Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс цагаан толгойн үсгийн дарааллаар олж чаддаг.	Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс үсгийн дарааллаар олж агуулгыг ойлгодог.
Цээжилсэн шүлгийн утгыг мэдэрч ойлгосны үндсэн дээр мэдрэмжээ илэрхийлэн, дуу хоолойн өнгө, биеийн хөдөлгөөн, айзам хэмнэл, зогсоц, өргөлт, хурд, нүүрний хувирлаа тохируулан дүрд тоглон, уран уншдаг.	Цээжилсэн шүлгийн утгыг ерөнхийд нь ойлгож, зарим үг, өгүүлбэрийн утгаас төрсөн мэдрэмжээ илэрхийлдэг.	Цээжилсэн шүлгийн утгыг ойлгосны үндсэн дээр дуу хоолойн өнгө, хэмнэлийг тохируулан уран уншдаг.	Цээжилсэн шүлгийн утгыг мэдэрч ойлгосны үндсэн дээр дуу хоолойн өнгө, биеийн хөдөлгөөн, хэмнэлийг дөхүүлэн дүрд тоглон, уран уншдаг.	Цээжилсэн шүлгийн утгыг мэдэрч ойлгосны үндсэн дээр мэдрэмжээ илэрхийлэн, дуу хоолойн өнгө, биеийн хөдөлгөөн, айзам хэмнэл, зогсоц, өргөлт, хурд, нүүрний хувирлаа тохируулан дүрд тоглон, уран уншдаг.

3.2.3. Үнэлгээний нэгж 3. Уншсанаа бүтээлчээр ойлгох

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
3.1з. Үлгэр, өгүүллэгийн үйл явдлыг уншихдаа гол баатрын хэлэх үгийг ургуулан бодож, төсөөлөх 3.1и. Уншсан үлгэр, өгүүллэгийн гол хэсгийн үйл явдлыг хэрхэн өрнөхийг таамаглах	Эхийн агуулгыг ургуулан бодож төсөөлж, таамаглах чадвараа харуулна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Эхийн агуулгыг ургуулан бодож төсөөлж, таамаглах чадвараа харуулна.	Оновчтой үг хэрэглэн, баатрын хэлэх үг яриаг өөрийн оюун дүгнэлтээр ургуулан бодож төсөөлдөг.
	Эхийн эхлэл хэсгээс үндэслэн цаашид гол хэсгийн үйл явдлыг хэрхэн өрнөхийг үндэслэлтэй таамагладаг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Оновчтой үг хэрэглэн, баатрын хэлэх үг яриаг өөрийн оюун дүгнэлтээр ургуулан бодож төсөөлдөг.	Зургийн тусламжтайгаар баатрын хэлэх үг яриаг ургуулан бодож төсөөлдөг.	Багшийн чиглүүлэг асуултын дэмжлэгтэйгээр баатрын хэлэх үг яриаг ургуулан бодож төсөөлдөг.	Баатрын хэлэх үгийг эргэцүүлэн бодож төсөөлдөг.	Оновчтой үг хэрэглэн, баатрын хэлэх үг яриаг өөрийн оюун дүгнэлтээр ургуулан бодож төсөөлдөг.
Эхийн эхлэл хэсгээс үндэслэн цаашид гол хэсгийн үйл явдлыг хэрхэн өрнөхийг үндэслэлтэй таамагладаг. (3.1и)	Эхийн үйл явдлыг хэрхэн өрнөхийг өөрийнхөөрөө ургуулан бодож, илэрхийлдэг.	Эхийн эхлэл хэсгийн аль нэгэн үйл явдал дээр үндэслэн төгсгөлийг таамагладаг.	Эхийн эхлэл хэсгийн үг, өгүүлбэрийн утгаас үндэслэн цаашид гол хэсгийн үйл явдлыг хэрхэн өрнөхийг үндэслэлтэй таамагладаг.	Эхийн эхлэл хэсгийн үг, өгүүлбэрийн утга, дүрийн үйлдлээс үндэслэн цаашид гол хэсгийн үйл явдлыг хэрхэн өрнөхийг үндэслэлтэй таамагладаг.

3.2.4. Үнэлгээний нэгж 4. Зөв бичих

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
3.2а. Утга ялгасан үгийг /н,г,х/ зөв дуудах, нүдлэх, өгүүлбэрт утга ялган зөв хэрэглэх 3.2б. Балархай эгшгийн эгшигжүүлэх үүргийг мэдэх, бичихдээ хэрэглэх 3.2в. Дараалсан гурван гийгүүлэгчийн дүрмээр зөв бичих 3.2г. Газар ус, улс орон зэрэг оноосон нэрийг ялгах, зөв бичих	Зөв бичих дүрмийг мэдэж, зохион найруулж бичихдээ алдаагүй зөв бичиж сурна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Зөв бичих дүрмийг мэдэж, зохион найруулж бичихдээ алдаагүй зөв бичиж сурна.	Утга ялгасан үгийг /н,г,х/ зөв уншиж, утгыг тодруулан өгүүлбэр зохион бичдэг.
	Дараалсан гурван гийгүүлэгчийн дүрмээр зөв бичихдээ балархай эгшгийн эгшигжүүлэх үүргийг мэддэг.
	Балархай эгшгийн эгшигжүүлэх үүргийг мэдэж, зөв бичиж чаддаг.
	Газар ус, улс орон зэрэг оноосон нэрийг ялгаж дүрмийн дагуу зөв бичдэг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Утга ялгасан үгийг /н, г, х/ зөв уншиж, утгыг тодруулан өгүүлбэр зохион бичдэг.	Өгүүлбэрээс /н, г, х/ утга ялгасан үгийг таньж, зөв уншдаг.	Утга ялгасан үгийг /н, г, х/ зөв уншиж, утгыг нь тайлбарлаж чаддаг.	Утга ялгасан үгийг /н, г, х/ зөв уншиж, өгүүлбэрт утгын алдаатай орсон үгийг таньж засаж чаддаг.	Утга ялгасан үгийг /н, г, х/ зөв уншиж, утгыг тодруулан өгүүлбэр зохион бичдэг.
Дараалсан гурван гийгүүлэгчийн дүрмээр зөв бичихдээ балархай эгшгийн эгшигжүүлэх үүргийг мэддэг.	Дараалсан гурван гийгүүлэгчийн дүрэм, балархай эгшгийн эгшигжүүлэх үүргийг мэддэг.	Дараалсан гурван гийгүүлэгчийн дүрмийн үүргийг, балархай эгшгийн эгшигжүүлэх үүргийг тус тус жишээн дээр тайлбарлаж чаддаг.	Дараалсан гурван гийгүүлэгчийн болон балархай эгшгийн эгшигжүүлэх дүрмийн алдаатай үгийг таньж, засаж чаддаг.	Дараалсан гурван гийгүүлэгчийн дүрмээр зөв бичихдээ балархай эгшгийн эгшигжүүлэх үүргийг мэддэг.
Газар ус, улс орон зэрэг оноосон нэрийг ялгаж дүрмийн дагуу зөв бичдэг.	Газар ус, улс орон зэрэг оноосон нэрийг өгүүлбэр, эхээс таньдаг.	Газар ус, улс орон зэрэг оноосон нэрийг жишээн дээр дүрмийн дагуу тайлбарлаж чаддаг.	Газар ус, улс орон зэрэг оноосон нэрийг буруу бичсэн алдаатай үгийг таньж засаж чаддаг.	Өгүүлбэр, эх зохиохдоо газар ус, улс орон зэрэг оноосон нэрийг дүрмийн дагуу зөв бичиж чаддаг.

3.2.5. Үнэлгээний нэгж 5. Зохион найруулж бичих

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
3.2д. Баярласан сэтгэлээ илэрхийлж, бүтцийн дагуу талархсан утгатай захидал бичих	Сурагч өгөгдсөн бүтэц, зааврын дагуу эх зохиож, найруулан бичиж чаддаг болсон байна. /үлгэр, ертөнцийн гурав, захидал, төлөвлөгөө, номын тэмдэглэл, зохиолын талаарх сэтгэгдэл/
3.2е. Хүсэл мөрөөдөл, зорилготойгоо нийцүүлж төлөвлөгөө зохион бичих	
3.2ж. Өгсөн зааврын дагуу тоочин жагсааж бичих	
3.2з. Өгсөн сэдэв, бүтцийн дагуу үлгэр зохиож бичих	
3.2и. Шүлэг, ертөнцийн гурвын хэлбэрийг дуурайн зохиож бичих	
3.2к. Өгсөн бүтцийн дагуу уншсан номоо тэмдэглэн бичих	
3.2л. Уншсан зохиолын талаар сэтгэгдлээ илэрхийлэн бичих	

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Сурагч өгөгдсөн бүтэц, зааврын дагуу эх зохиож, найруулан бичиж чаддаг болсон байна. /богино өгүүллэг буюу 4-5 өгүүлбэр бүхий эх, мэндчилгээ, талархал, гэр бүлийн танилцуулга, болсон явдал/	Баярлаж, талархсан сэтгэлээ илэрхийлж бүтцийн дагуу талархсан утгатай захидал бичдэг.
	Хүсэл мөрөөдөл, зорилготойгоо нийцүүлэн төлөвлөгөө зохиож бичдэг.
	Өгсөн сэдэв, бүтцийн дагуу үлгэр зохиож бичихдээ эхлэл хэсэгт цаг хугацаа, дүр, орон байрыг, гол хэсэгт баатруудад тохиолдсон явдал, асуудал, бэрхшээл гарсныг, төгсгөл хэсэгт бэрхшээлээ яаж шийдсэн болохыг тусган санаагаа ойлгомжтой, утгын уялдаа холбоотой зөв бичих дүрмийн алдаагүй бичдэг.
	Өгсөн бүтцийн дагуу уншсан номын тэмдэглэл хөтлөн, зохиолын талаарх төрсөн сэтгэгдлээ жишээ татан, ойлгомжтой илэрхийлэн найруулж бичдэг.
	Өгсөн заавар, зургийн дагуу хоолны жорыг дарааллуулан тоочин жагсааж, оновчтой үг хэрэглэн, үзсэн зөв бичих дүрмийн хүрээнд алдаагүй бичдэг.
	Ертөнцийн гурвын хэлбэрийг дуурайн, алдаагүй зөв зохион бичдэг.
	Хэлц үгийн тайлбарыг ойлгон, өгүүлбэр зохиохдоо хэрэглэж чаддаг

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Баярлаж, талархсан сэтгэлээ илэрхийлж бүтцийн дагуу талархсан утгатай захидал бичдэг.	Баярлаж, талархсан сэтгэлээ ерөнхийд нь илэрхийлж бичдэг.	Талархсан утгатай захидал бичихдээ багшийн өгсөн зааврын дагуу талархсан сэтгэлээ ойлгомжтой илэрхийлэн бичдэг.	Талархсан утгатай захидал бичихдээ талархсан сэтгэлээ бүтцийн дагуу утгын уялдаатай илэрхийлэн, ихэнх тохиолдолд үзсэн зөв бичих дүрмийн хүрээнд алдаагүй бичдэг.	Талархсан утгатай захидал бичихдээ бүтцийн дагуу хэнд, юунд талархсан сэтгэлээ утгын уялдаа холбоотой, оновчтой илэрхийлэн, үзсэн зөв бичих дүрмийн хүрээнд алдаагүй зөв бичдэг.
Хүсэл мөрөөдөл, зорилготойгоо нийцүүлэн төлөвлөгөө зохиож бичдэг.	Хүсэл мөрөөдөл, зорилгоо тодорхойлон, санаагаа ерөнхийд нь төлөвлөн бичдэг.	Хүсэл мөрөөдөл, зорилгоо тодорхойлон, бэлэн загварын дагуу төлөвлөгөө зохиож бичдэг.	Санаагаа, ойлгомжтой илэрхийлэн, хүсэл мөрөөдөл, зорилготойгоо нийцүүлэн, төлөвлөгөө зохиож бичдэг.	Санаагаа, ойлгомжтой илэрхийлэн, хүсэл мөрөөдөл, зорилготойгоо нийцүүлэн, бүтцийн дагуу зөв төлөвлөгөө зохиож бичдэг.
Өгсөн сэдэв, бүтцийн дагуу үлгэр зохиож бичихдээ эхлэл хэсэгт цаг хугацаа, дүр, орон байрыг, гол хэсэгт баатруудад тохиолдсон явдал, асуудал, бэрхшээл гарсныг, төгсгөл хэсэгт бэрхшээлээ яаж шийдсэн болохыг тусган санаагаа ойлгомжтой, утгын уялдаа холбоотой зөв бичих дүрмийн алдаагүй бичдэг.	Өгсөн сэдэв, бүтцийн дагуу үлгэр зохиож бичихдээ ерөнхий санаагаа ойлгомжтой илэрхийлж бичдэг	Өгсөн сэдэв, бүтцийн дагуу үлгэр зохиож бичихдээ ерөнхий санаагаа утгын уялдаатай илэрхийлж бичдэг	Өгсөн сэдэв, бүтцийн дагуу үлгэр зохиож бичихдээ эхлэл хэсэгт цаг хугацаа, дүр, гол хэсэгт ямар үйл явдал хэрхэн өрнөснийг, төгсгөл хэсэгт бэрхшээлээ яаж шийдсэнээ ойлгомжтой, үзсэн зөв бичгийн дүрмийн хүрээнд алдаагүй бичдэг.	Өгсөн сэдэв, бүтцийн дагуу үлгэр зохиож бичихдээ эхлэл хэсэгт цаг хугацаа, дүр, орон байрыг, гол хэсэгт баатруудад тохиолдсон явдал, асуудал, бэрхшээл гарсныг, төгсгөл хэсэгт бэрхшээлээ яаж шийдсэн болохыг тусган санаагаа ойлгомжтой, утгын уялдаа холбоотой зөв бичих дүрмийн алдаагүй хурдтай бичдэг.
Өгсөн бүтцийн дагуу уншсан номын тэмдэглэл хөтлөн, зохиолын талаарх төрсөн сэтгэгдлээ жишээ татан, ойлгомжтой илэрхийлэн найруулж бичдэг.	Өгсөн бүтцийн дагуу уншсан номын тэмдэглэл хөтөлдөг	Уншсан номын талаарх төрсөн сэтгэгдлээ ерөнхийд нь илэрхийлж бичдэг.	Өгсөн бүтцийн дагуу уншсан номын тэмдэглэл хөтлөн, зохиолын талаарх төрсөн сэтгэгдлээ ойлгомжтой илэрхийлж, найруулан бичдэг.	Өгсөн бүтцийн дагуу уншсан номын тэмдэглэл хөтлөн, зохиолын талаарх төрсөн сэтгэгдлээ жишээ татан, ойлгомжтой илэрхийлж найруулан бичдэг.
Өгсөн заавар, зургийн дагуу дарааллуулан хоолны жорыг тоочин жагсааж, оновчтой үг хэрэглэн, үзсэн зөв бичих дүрмийн хүрээнд алдаагүй бичдэг.	Өгсөн заавар, зургийн дарааллыг алдагдуулан, тоочиж бичдэг.	Өгсөн заавар, зургийн дагуу дарааллыг алдагдуулан, тоочин жагсааж, зарим тохиолдолд алдаагүй зөв бичдэг.	Өгсөн заавар, зургийн дагуу дарааллуулан тоочин жагсааж, оновчтой үг хэрэглэн, ихэнх тохиолдолд алдаагүй зөв бичдэг.	Өгсөн заавар, зургийн дагуу дарааллуулан тоочин жагсааж, оновчтой үг хэрэглэн, үзсэн зөв бичих дүрмийн хүрээнд алдаагүй бичдэг.

Ертөнцийн гурвын хэлбэрийг дуурайн, алдаагүй зөв зохион бичдэг. (3.2и)	Ертөнцийн гурвын сүүл холболтыг дуурайн зохиож бичдэг.	Ертөнцийн гурвын толгой холбох хэлбэрийг дуурайн зарим тохиолдолд алдаагүй зохион бичдэг.	Ертөнцийн гурвын толгой холболт, мөр дэх үгийн тоо гэсэн хэлбэрийг дуурайн ихэнх үгийг алдаагүй зохион бичдэг.	Ертөнцийн гурвын толгой, сүүл холболт, мөр дэх үгийн тоо зэрэг хэлбэрийг дуурайн, үзсэн зөв бичих дүрмийн хүрээнд алдаагүй бичдэг.
Хэлц үгийн тайлбарыг ойлгон, өгүүлбэр зохиохдоо хэрэглэж чаддаг. (3.4г)	10-15 хэлц үгийг цээжилсэн.	10-15 хэлц үгийн тайлбарыг уншаад ойлгосноо бусдад ярьж чаддаг.	10-15 хэлц үгийн тайлбарыг ойлгон, хэлц үгийг өгүүлбэрт оруулан зохиож чаддаг.	10-15 хэлц үгийн тайлбарыг ойлгон, хэлц үгийг өгүүлбэрт оруулан зөв бичгийн дүрмийн алдаагүй зохиож чаддаг.

Тайлбар:

- “3.4а. Эх, өгүүлбэрээс хэн? юу? яав? яаж? яагаад? ямар учраас? гэсэн асуултад хариулагдах үгсийг олох, хэрэглэх” гэсэн суралцахуйн зорилт буюу чадварыг багш нар ямар ч төрлийн эх зохион бичүүлэх явцад шалгуур болгон хэрэглэнэ.
- “3.4б. Уншсан эхээс анхааруулах өгүүлбэрийг ялган таних, бичихдээ анхаарлын тэмдэг, таслал, цэгийг оновчтой хэрэглэх” гэсэн хэлзүйн ойлголт бүхий суралцахуйн зорилтыг ямар ч эх зохиоход үнэлгээний шалгуур болгон хэрэглэж болно.
- Хэлц үгийг 2 дугаар ангид “2.4г. Хэлц үгийн тайлбарыг уншиж ойлгох, цээжилж тогтоох” гэсэн суралцахуйн зорилтын хүрээнд цээжилсэн байхаар оруулсан хэдий ч анги ахих тусам энэ чадварыг эзэмших нь өргөжиж байгаа учраас зөвхөн 3, 5 дугаар ангид үнэлэхээр оруулсан болно. Тиймээс 3 дугаар ангийн сурагчид гүйцэтгэлийн 1-р түвшинд хэлц үгийг цээжилсэн байхаар тусгав.

3.2.6. Үнэлгээний нэгж 6. Сонсож ойлгосноо илэрхийлэх

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
3.3а. Болсон явдал, сонссон зүйлийн учир шалтгааныг бусдын өмнө тодорхой ярих	Бусдын өмнө тодорхой, чөлөөтэй ярьдаг.
3.3б. Хэлэлцүүлгийн үед бусдын ярианаас лавшруулан, тодруулан асуух замаар идэвхтэй сонссоноо харуулах	Хэлэлцэж, ярилцахдаа идэвхтэй сонсож сурна.
3.3в. Хэлэлцэх, ярилцах үед хүсэл, санаа бодлоо бусдын өмнө чөлөөтэй илэрхийлэх	

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Бусдын өмнө тодорхой, чөлөөтэй ярьдаг.	Харсан сонссон зүйлийн учир шалтгааныг бусдын өмнө тодорхой чөлөөтэй ярьдаг.
Хэлэлцэж, ярилцахдаа идэвхтэй сонсож сурна.	Хэлэлцүүлгийн үед, эсвэл ярилцаж байхдаа бусдын ярианаас лавшруулан, тодруулан асуух замаар идэвхтэй сонсдог.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Харсан сонссон зүйлийн учир шалтгааныг бусдын өмнө тодорхой чөлөөтэй ярьдаг. (3.3а), (3.3в)	Харсан сонссон зүйлийн тухай чөлөөтэй ярьдаг.	Харсан сонссон зүйлийн учир шалтгааныг бусдын өмнө чөлөөтэй ярьдаг.	Харсан сонссон зүйлийн учир шалтгааныг бусдын өмнө тодорхой чөлөөтэй ярьдаг.	Харсан сонссон зүйлийн учир шалтгааныг жишээлэн тайлбарлаж, бусдын өмнө тодорхой чөлөөтэй ярьдаг.
Хэлэлцүүлгийн үед бусдын ярианаас лавшруулан, тодруулан асуух замаар идэвхтэй сонсдог. (3.3б)	Хэлэлцүүлгийн үед анхаарал нь зарим үед сарниж, бусадтайгаа харилцдаггүй.	Хэлэлцүүлгийн үед бусдыг хүндэтгэн, анхаарлаа төвлөрүүлэн сонсдог.	Хэлэлцүүлгийн үед бусдыг хүндэтгэн, ойлгож сонсдог.	Хэлэлцүүлгийн үед бусдын ярианаас лавшруулан, тодруулан асуух замаар идэвхтэй сонсдог.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. IV АНГИ

4.1. IV АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Сурагч нь “зөв, хурдан, ойлгож” унших, уран унших, уншсанаа тайлбарлах, ялгах, харьцуулах, унших явцдаа төсөөлөх, таамаглах, санаа бодлоо тусган зохион найруулах, зөв бичгийн дүрмийг баримтлан бичих, эх хэлээрээ зөв, цэгцтэй, өөртөө итгэлтэй ярих, санал бодлоо солилцон хэлэлцэх чадвар эзэмшиж, хэл соёлоо хүндэтгэдэг иргэн төлөвшинө.

4.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ

4.2.1 Үнэлгээний нэгж 1. Уншсанаа ойлгох

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
4.1а. Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс олж, агуулгыг ойлгох 4.1б. Уншсан эхийн болон үлгэр, өгүүлэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах 4.1в. Уншсан эх, үлгэр, өгүүлэгийн бүтцийн хэсгүүдийн учир шалтгааныг тайлбарлах 4.1г. Шүлэг дэх хоёр зүйлийн ижил төстэй шинжийг харьцуулан адилтган дүрсэлснийг тайлбарлах 4.1д. Эхэд ашигласан баримт ба өгүүлэгчийн үзэл бодлыг илэрхийлсэн хэсгийг ялгах 4.1е. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэгт баатруудын зан чанар, үзэл бодолд гарсан өөрчлөлтийг харьцуулах 4.1ж. Урилга, уриалга, номын танилцуулга, сонины мэдээ, захидал зэргийн зорилго, бүтцийг тайлбарлах	Сурагч эхийн утгыг ойлгож, зөв хурдан уншаад, уншсан зүйлээ тоочиж, тайлбарлаж, ялгаж, харьцуулж чаддаг болно.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Сурагч эхийн утгыг ойлгож, зөв хурдан уншаад, уншсан зүйлээ тоочиж, тайлбарлаж, ялгаж, харьцуулж чаддаг болно.	Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс үсгийн дарааллаар олж, эх, өгүүлбэрийн агуулгыг ойлгодог.
	Эхийн төгсгөл хэсгээс гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг зөв сонгосны үндсэн дээр зохиолчийн илэрхийлэх гэсэн санааг хэлэн ойлгосноо харуулдаг.
	Уншсан эхийн гол, төгсгөл хэсгүүдийн үйл явдал юунаас шалтгаалж өрнөснийг оновчтой жишээ татан тайлбарладаг.
	Адилтган дүрсэлснийг тайлбарлахдаа юуг юутай, ямар шинжээр нь адилтгасныг харьцуулдаг.
	Өгүүлэгчийн үзэл бодлыг илэрхийлсэн хэсэг болон түүнийг баталсан баримтыг ялгадаг. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэгт баатруудын зан чанар, үзэл бодолд гарсан өөрчлөлтийг оновчтой жишээ татан харьцуулдаг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс үсгийн дарааллаар олж, эх, өгүүлбэрийн агуулгыг ойлгодог.	Уншсан эхээс танил биш үгийг олж, ойр орчмын үг өгүүлбэрээс таамагладаг.	Уншсан эхээс танил биш үгийг тайлбар толь бичгээс үсгийн дарааллаар олж, утгыг мэддэг.	Уншсан эхээс танил биш үгийн утгыг таамагласнаа тайлбар толь бичгийн утгатай харьцуулдаг.	Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс үсгийн дарааллаар олж, эх, өгүүлбэрийн агуулгыг ойлгодог.
Эхийн төгсгөл хэсгээс гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг зөв сонгосны үндсэн дээр зохиолчийн илэрхийлэх гэсэн санааг хэлэн ойлгосноо харуулдаг.	Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгүүдийн үйл явдлыг тоочиж, ойлгосноо харуулдаг.	Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэг тус бүрийн утгыг тайлбарлаж ойлгосноо харуулдаг.	Эхийн төгсгөл хэсгээс гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг зөв сонгон, ойлгосноо харуулдаг.	Эхийн төгсгөл хэсгээс гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг зөв сонгосны үндсэн дээр зохиолчийн илэрхийлэх гэсэн санааг хэлэн ойлгосноо харуулдаг.
Уншсан эхийн гол, төгсгөл хэсгүүдийн үйл явдал юунаас шалтгаалж өрнөснийг оновчтой жишээ татан тайлбарладаг.	Эхийн үйл явдлыг зөв дарааллуулж, тоочин ярьдаг.	Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэг тус бүрийн утгыг тайлбарладаг.	Гол, төгсгөл хэсэг дэх үйл явдал юунаас болж өрнөж байгааг “Ямар учраас, яагаад, юуны тулд” гэсэн асуулт хэрэглэн тайлбарладаг.	Гол, төгсгөл хэсэг дэх үйл явдал юунаас болж өрнөж байгааг оновчтой жишээ татан тайлбарладаг.
Адилтган дүрсэлснийг тайлбарлахдаа юуг юутай, ямар шинжээр нь адилтгасныг харьцуулдаг.	Адилтган дүрсэлснийг тайлбарлахдаа хоёр зүйлийн ижил төстэй шинжийг тус тусад нь илэрхийлэн хэлдэг.	Адилтган дүрсэлснийг тайлбарлахдаа багшийн дэмжлэгээр хоёр зүйлийн ижил төстэй шинжийг ажиглан харьцуулдаг.	Адилтган дүрсэлснийг тайлбарлахдаа юуг юутай адилтгасныг харьцуулдаг.	Адилтган дүрсэлснийг тайлбарлахдаа юуг юутай, ямар шинжээр нь адилтгасныг харьцуулдаг.
Өгүүлэгчийн үзэл бодлыг илэрхийлсэн хэсэг болон түүнийг баталсан баримтыг ялгадаг.	Өгүүлэгчийн үзэл бодлыг илэрхийлсэн хэсгийг ялгадаг.	Өгүүлэгчийн үзэл бодлыг баталсан баримтыг ялгадаг.	Өгүүлэгчийн үзэл бодлыг илэрхийлсэн хэсэг, баталсан баримтыг асуултын тусламжтайгаар ялгадаг.	Өгүүлэгчийн үзэл бодлыг илэрхийлсэн хэсэг болон түүнийг баталсан баримтыг ялгадаг.
Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэгт баатруудын зан чанар, үзэл бодолд гарсан өөрчлөлтийг оновчтой жишээ татан харьцуулдаг.	Эхлэл, гол хэсэгт баатруудын хийсэн үйлдлийг тоочдог.	Баатруудын зан чанаруудын тухай илэрхийлэн ярьдаг.	Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэгт баатруудын зан чанарт гарсан өөрчлөлтийг жишээ татан харьцуулдаг.	Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэгт баатруудын зан чанар, үзэл бодолд гарсан өөрчлөлтийг оновчтой жишээ татан харьцуулдаг.

4.2.2. Үнэлгээний нэгж 2. Ойлгож, уран унших

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
4.1з. Хурд, дууны өнгөө тохируулан урнаар уншиж, шүлгийн утгыг ойлгосноо харуулах 4.3г. Зохиолын баатруудын харилцан ярианы утгыг ойлгосноо жүжиглэн үзүүлэх	Сурагч дүрд тоглож, зохиолын утгыг ойлгосноо харуулна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Сурагч дүрд тоглож, зохиолын утгыг ойлгосноо харуулна.	Зохиолын баатруудын харилцан ярианы утгыг ойлгосны үндсэн дээр дуу хоолойн өнгө, биеийн хөдөлгөөн, нүүрний хувирлаа тохируулан дүрд тоглодог.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Зохиолын баатруудын харилцан ярианы утгыг ойлгосны үндсэн дээр дуу хоолойн өнгө, биеийн хөдөлгөөн, нүүрний хувирлаа тохируулан дүрд тоглодог.	Зохиолын баатруудын харилцан яриаг эхээс ялган, юу ярилцсаныг өөрийнхөө ойлгосноор илэрхийлдэг.	Зохиолын баатруудын харилцан ярианы утгыг ойлгосны үндсэн дээр дуу хоолойн өнгөө тохируулан дүрд тоглодог.	Зохиолын баатруудын харилцан ярианы утгыг ойлгосны үндсэн дээр дуу хоолойн өнгө, биеийн хөдөлгөөн, тохируулан дүрд тоглодог.	Зохиолын баатруудын харилцан ярианы утгыг ойлгосны үндсэн дээр дуу хоолойн өнгө, биеийн хөдөлгөөн, нүүрний хувирлаа тохируулан дүрд тоглодог.

4.2.3. Үнэлгээний нэгж 3. Уншсанаа бүтээлчээр ойлгох

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
4.1и. Уншсан зохиолын баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож төсөөлөх 4.1к. Эхийн үйл явдлын төгсгөлийг үндэслэлтэйгээр таамаглах	Зохиолыг унших явцдаа төсөөлж, таамаглах чадвараа харуулна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Зохиолыг унших явцдаа төсөөлж, таамаглах чадвараа харуулна.	Уншсан зохиолын баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож, өөрийн оюун дүгнэлтээр төсөөлдөг
	Эхийн эхлэл, гол хэсгийн үйл явдал дээр үндэслэн төгсгөлийг таамагладаг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Уншсан зохиолын баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож, өөрийн оюун дүгнэлтээр төсөөлдөг.	Бусдын хэлсэн жишээг дуурайн баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож, төсөөлдөг.	Ямар? гэсэн асуултаар дэлгэрүүлэн, баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож, өөрийн оюун дүгнэлтээр төсөөлдөг.	Ямар, яг юу шиг гэсэн асуултаар дэлгэрүүлэн, баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож, өөрийн оюун дүгнэлтээр төсөөлдөг.	Оновчтой үг сонгон, уншсан зохиолын баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож, өөрийн оюун дүгнэлтээр төсөөлдөг.
Эхийн эхлэл, гол хэсгийн үйл явдал дээр үндэслэн төгсгөлийг таамагладаг.	Эхийн эхлэл, гол хэсгийн үйл явдал дээр үндэслэхгүйгээр үйл явдлыг үргэлжлүүлэн зохиосон.	Эхийн эхлэл, гол хэсгийн үйл явдал дээр үндэслэн багшийн асуултын тусламжтайгаар төгсгөлийг таамагладаг.	Эхийн эхлэл, гол хэсгийн аль нэгэн үйл явдал дээр үндэслэн төгсгөлийг таамагладаг.	Эхийн эхлэл, гол хэсгийн үйл явдал, үг, өгүүлбэрээс үндэслэн төгсгөлийг таамагладаг.

4.2.4. Үнэлгээний нэгж 4. Зөв бичих

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
4.2а. Дуудлага ижил зарим үгийг утга, бичлэгээр нь ялгаж, өгүүлбэрт зөв хэрэглэх (буурь-буйр, хууль-хуйл, тууль-туйл) 4.2б. Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүргийг мэдэх, зөв бичих 4.2в. ж, ч, ш-ийн дараа “и” бичдэгийн учрыг мэдэх, зөв бичих 4.2г. Хатуу, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэдэх, зөв бичих	Зөв бичих дүрмийг мэдэж, зохион найруулж бичихдээ алдаагүй зөв бичиж сурна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Зөв бичих дүрмийг мэдэж, зохион найруулж бичихдээ алдаагүй зөв бичиж сурна.	Дуудлага ижил зарим үгийг утга, бичлэгээр нь ялгаж, зөв уншиж, утгыг тодруулан өгүүлбэр зохион бичдэг.
	Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүрэг, ж,ч,ш-ийн дараа “и” бичдэг дүрэм, хатуу, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэдэж, зохиож, найруулж бичихдээ дүрмийг хэрэглэж зөв бичиж сурна.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Дуудлага ижил зарим үгийг утга, бичлэгээр нь ялгаж, зөв уншиж, утгыг тодруулан өгүүлбэр зохион бичдэг.	Эхээс дуудлага ижил зарим үгийг утга, бичлэгээр нь ялган таньж, зөв уншдаг.	Дуудлага ижил зарим үгийг утга, бичлэгээр нь ялгаж, утгыг нь тайлбарлаж чаддаг.	Өгүүлбэрт дуудлага ижил зарим үгийг утгын хувьд алдаатай бичсэнийг таньж засаж чаддаг.	Дуудлага ижил зарим үгийг утгыг тодруулан өгүүлбэр зохион бичдэг.

Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүрэг, ж,ч,ш-ийн дараа “и” бичдэг дүрэм, хатуу, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэдэж, зохиож, найруулж бичихдээ дүрмийг хэрэглэж зөв бичиж сурна. (4.2б, 4.2в,4.2г)	Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүрэг, ж,ч,ш-ийн дараа “и” бичдэг дүрэм, хатуу, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэддэг	Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүрэг, ж,ч,ш-ийн дараа “и” бичдэг дүрэм, хатуу, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг дүрмийн зүй тогтлыг жишээн дээр тайлбарлаж чаддаг	Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүрэг, ж,ч,ш-ийн дараа “и” бичдэг дүрэм, хатуу, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийн дүрмийн алдаатай үгийг таньж, засаж чаддаг	Өгүүлбэр, эх зохиохдоо балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүрэг, ж,ч,ш-ийн дараа “и” бичдэг дүрэм, хатуу, зөөлний тэмдгийн тусгаарлах дүрэмтэй үгийг алдаагүй зөв бичдэг
---	---	--	---	--

4.2.5. Үнэлгээний нэгж 5. Зохион найруулж бичих

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
4.2д. Үйл явдлыг өрнүүлэн, утгын уялдаа холбоотой богино өгүүллэг зохиох 4.2е. Өгсөн бүтцийн дагуу утгын уялдаа холбоотой бахархсан утгатай захидал бичих 4.2ж. Бусдыг сайн сайхан зүйлд уриалж, бүтцийн дагуу уриалга бичих 4.2з. Өгсөн асуултын хүрээнд үйл явдлын товч мэдээ бичих 4.2и. Хүндэтгэлийн үг хэрэглэн, бүтцийн дагуу урилга бичих 4.2к. Бүтцийн дагуу үлгэр зохиохдоо баатрын гадаад дүр байдлыг дүрслэн бичих 4.2л. Шүлгийн хэлбэрийг дуурайж зохион бичих 4.2м. Уншсан номыг танилцуулж бичихдээ сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэх	Сурагч өгөгдсөн бүтэц, зааврын дагуу эх зохиож, сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэн найруулан хурдтай бичиж чаддаг болсон байна. /богино, өгүүллэг, үлгэр, захидал, номын танилцуулга, товч мэдээ, урилга, уриалга, шүлэг/

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Сурагч өгөгдсөн бүтэц, зааврын дагуу эх зохиож, сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэн найруулан хурдтай бичиж чаддаг болсон байна. /богино, өгүүллэг, үлгэр, захидал, номын танилцуулга, товч мэдээ, урилга, уриалга, шүлэг/	Шүлгийн мөр бүр дэх үгийн тоо, айзам хэмнэлийг дуурайж зохиохдоо өөрийн санаагаар баяжуулан, ойлгомжтой, алдаагүй, хичээнгүй бичсэн байна.
	Захидалдаа бахархсан утгатай үг болон холбох үг хэрэглэн, эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй, цогцолборуудыг догол мөрөөр зааглан, утгын уялдаа холбоотой, ойлгомжтой, алдаагүй, хичээнгүй, хурдтай бичиж чаддаг болно.
	Болсон үйл явдлын мэдээг хэн, хаана, хэзээ, юуг, яагаад, хэрхэн? гэсэн асуултын хүрээнд бүтцийн дагуу ойлгомжтой алдаагүй, зөв, хичээнгүй, хурдтай бичиж чаддаг.
	Номын танилцуулгадаа өөрт төрсөн сэтгэгдэл болон дүр, үг хэллэгээс мэдэрсэн мэдрэмжээ илэрхийлэн, хэлц үг хэрэглэн, ойлгомжтой, зөв бичгийн дүрмийн алдаагүй, хичээнгүй, хурдтай бичиж чаддаг.
	Бусдыг сайн сайхан зүйлд уриалж, бүтцийн дагуу уриалга зохиохдоо ойлгомжтой, алдаагүй, зөв, хичээнгүй бичиж чаддаг.
	Хүндэтгэлийн үг хэрэглэн бүтцийн дагуу урилга зохиохдоо ойлгомжтой, алдаагүй, зөв, хичээнгүй бичиж чаддаг.
	Эхийн үйл явдлыг өрнүүлэн богино өгүүллэг зохиохдоо ойлгомжтой, утгын уялдаа холбоотой, бүтцийн дагуу алдаагүй, зөв, хичээнгүй, хурдтай бичиж чаддаг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Шүлгийн мөр бүр дэх үгийн тоо, айзам хэмнэлийг дуурайж зохиохдоо өөрийн санаагаар баяжуулан, ойлгомжтой, алдаагүй, хичээнгүй бичсэн байна.	Шүлгийн мөр бүр дэх үгийн тоог дуурайж зохиохдоо ойлгомжтой бичсэн байна.	Шүлгийн мөр бүр дэх үгийн тоо, айзам хэмнэлийг дуурайж зохиохдоо ойлгомжтой, бичсэн байна.	Шүлгийн мөр бүр дэх үгийн тоо, айзам хэмнэлийг дуурайж зохиохдоо ойлгомжтой, алдаагүй, хичээнгүй бичсэн байна.	Шүлгийн мөр бүр дэх үгийн тоо, айзам хэмнэлийг дуурайж зохиохдоо өөрийн санаагаар баяжуулан, ойлгомжтой, алдаагүй, хичээнгүй бичсэн байна.
Захидалдаа бахархсан утгатай үг болон холбох үг хэрэглэн, эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй, цогцолборуудыг догол мөрөөр зааглан, утгын уялдаа холбоотой, ойлгомжтой, алдаагүй, хичээнгүй, хурдтай бичиж чаддаг болно.	Хэн нэгнээр бахархсанаа ойлгомжтой илэрхийлэн бичиж чаддаг.	Захидалдаа бахархсан утгатай үг хэрэглэн, эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй, ойлгомжтой бичиж чаддаг	Захидалдаа бахархсан утгатай үг хэрэглэн, эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй, утгын уялдаа холбоотой, ойлгомжтой, алдаагүй, хичээнгүй бичиж чаддаг.	Захидалдаа бахархсан утгатай үг болон холбох үг хэрэглэн, эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй, цогцолборуудыг догол мөрөөр зааглан, утгын уялдаа холбоотой, ойлгомжтой, алдаагүй, хичээнгүй бичиж чаддаг.
Болсон үйл явдлын мэдээг хэн, хаана, хэзээ, юуг, яагаад, хэрхэн? гэсэн асуултын хүрээнд бүтцийн дагуу ойлгомжтой алдаагүй, зөв, хичээнгүй, хурдтай бичиж чаддаг.	Болсон үйл явдлын мэдээг тоочин дарааллуулан бичдэг.	Болсон үйл явдлын мэдээг хэн, хаана, хэзээ, юуг, яасан гэсэн асуултын хүрээнд ойлгомжтой бичиж чаддаг	Болсон үйл явдлын мэдээг хэн, хаана, хэзээ, юуг, яагаад, хэрхэн? гэсэн асуултын хүрээнд ойлгомжтой алдаагүй, хичээнгүй, хурдтай бичиж чаддаг.	Болсон үйл явдлын мэдээг хэн, хаана, хэзээ, юуг, яагаад, хэрхэн? гэсэн асуултын хүрээнд бүтцийн дагуу ойлгомжтой алдаагүй, зөв, хичээнгүй бичиж чаддаг.
Номын танилцуулгадаа өөрт төрсөн сэтгэгдэл болон дүр, үг хэллэгээс мэдэрсэн мэдрэмжээ илэрхийлэн, хэлц үг хэрэглэн, ойлгомжтой, зөв бичгийн дүрмийн алдаагүй, хичээнгүй, хурдтай бичиж чаддаг.	Номын танилцуулгаа ойлгомжтой бичиж чаддаг.	Номын танилцуулгадаа өөрт төрсөн сэтгэгдлээ илэрхийлэн ойлгомжтой бичиж чаддаг.	Номын танилцуулгадаа өөрт төрсөн сэтгэгдэл болон дүр, үг хэллэгээс мэдэрсэн мэдрэмжээ ойлгомжтой илэрхийлэн, алдаагүй, хурдтай бичиж чаддаг.	Номын танилцуулгадаа өөрт төрсөн сэтгэгдэл болон дүр, үг хэллэгээс мэдэрсэн мэдрэмжээ илэрхийлэн, хэлц үг хэрэглэн, ойлгомжтой, зөв бичгийн дүрмийн алдаагүй, хурдтай, хичээнгүй бичиж чаддаг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Бусдыг сайн сайхан зүйлд уриалж, бүтцийн дагуу уриалга зохиохдоо ойлгомжтой, алдаагүй, зөв, хичээнгүй бичиж чаддаг.	Уриалга зохиохдоо ойлгомжтой, бичиж чаддаг.	Бусдыг сайн сайхан зүйлд уриалж уриалга зохиохдоо ойлгомжтой бичиж чаддаг.	Бусдыг сайн сайхан зүйлд уриалж уриалга зохиохдоо ойлгомжтой, алдаагүй, хичээнгүй бичиж чаддаг.	Бусдыг сайн сайхан зүйлд уриалж, бүтцийн дагуу уриалга зохиохдоо ойлгомжтой, алдаагүй, зөв, хичээнгүй бичиж чаддаг.
Хүндэтгэлийн үг хэрэглэн бүтцийн дагуу урилга зохиохдоо ойлгомжтой, алдаагүй, зөв, хичээнгүй бичиж чаддаг.	Урилга зохиохдоо ойлгомжтой бичиж чаддаг.	Бүтцийн дагуу урилга зохиохдоо ойлгомжтой бичиж чаддаг.	Хүндэтгэлийн үг хэрэглэн бүтцийн дагуу урилга зохиохдоо ойлгомжтой, алдаагүй, хичээнгүй бичиж чаддаг.	Хүндэтгэлийн үг хэрэглэн бүтцийн дагуу урилга зохиохдоо ойлгомжтой, алдаагүй, зөв, хичээнгүй бичиж чаддаг.
Эхийн үйл явдлыг өрнүүлэн богино өгүүллэг зохиохдоо ойлгомжтой, утгын уялдаа холбоотой, бүтцийн дагуу алдаагүй, зөв, хичээнгүй, хурдтай бичиж чаддаг.	Эхийн үйл явдлыг өрнүүлэн богино өгүүллэг зохиохдоо үйл явдлыг тоочин бичиж чаддаг.	Эхийн үйл явдлыг өрнүүлэн богино өгүүллэг зохиохдоо ойлгомжтой бичиж чаддаг.	Эхийн үйл явдлыг өрнүүлэн богино өгүүллэг зохиохдоо ойлгомжтой, алдаагүй, зөв, хичээнгүй, бичиж чаддаг.	Эхийн үйл явдлыг өрнүүлэн богино өгүүллэг зохиохдоо хэлц үг болон холбох үг хэрэглэн, ойлгомжтой, утгын уялдаа холбоотой, алдаагүй, зөв, хичээнгүй, цогцолборуудыг догол мөрөөр зааглан бичиж чаддаг.

Тайлбар:

- “4.4а. Харин, ийм учраас, цаашилбал, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж, ба, бөгөөд зэрэг холбох үгсийг хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох
- 4.4б. Уриалсан, зөвлөсөн өнгө аясыг илтгэх үг хэллэгийг оновчтой хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох
- 4.4в. Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох” гэсэн суралцахуйн зорилт буюу чадварыг багш нар, ямар ч төрлийн эх зохион бичүүлэх явцад шалгуур болгон хэрэглэнэ.

4.2.6. Үнэлгээний нэгж 6. Бусдыг хүндэтгэн сонсох, яриагаа төлөвлөн илэрхийлэх

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
4.3а. Сэдвийн хүрээнд яриагаа төлөвлөж, бэлтгэн, ойлгомжтой, цэгцтэй илэрхийлэн ярих	Сурагч яриагаа төлөвлөн, санаа бодлоо цэгцтэй, ойлгомжтой илэрхийлж сурна.
4.3б. Хэлэлцүүлэгт шинэ санаа нэмж оролцох, бусдын яриаг дуустал хүлээцтэй сонсох	Хэлэлцэж, ярилцахдаа бусдын санаа бодлыг дүгнэн, хүлээцтэй сонсож сурна.
4.3в. Хэлэлцүүлгийн явцад бусдын санаа бодлыг анхааралтай сонсож, дүгнэх	Хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож сурна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Сурагч яриагаа төлөвлөн, санаа бодлоо цэгцтэй, ойлгомжтой илэрхийлж сурна.	Яриагаа бүтцийн дагуу төлөвлөж, үгээ сонгон бэлтгэн, бусдад ойлгомжтой, цэгцтэй илэрхийлж чаддаг.
Хэлэлцэж, ярилцахдаа бусдын санаа бодлыг дүгнэн, хүлээцтэй сонсож сурна.	Хэлэлцүүлэг, ярилцлагын явцад бусдын яриаг таслахгүйгээр дуустал хүлээцтэй, ойлгож сонсдог.
Хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож сурна.	Шинэ баатар, шинэ орчин нэмж, зохиолын үйл явдлыг хэлэлцэхдээ бусдын үзэл бодлыг дүгнэдэг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Яриагаа бүтцийн дагуу төлөвлөж, үгээ сонгон бэлтгэн, бусдад ойлгомжтой, цэгцтэй илэрхийлж чаддаг.	Яриагаа бусдад ойлгомжтой илэрхийлж чаддаг.	Яриагаа бүтцийн дагуу төлөвлөж, зураг сонгон бэлтгэн, бусдад ойлгомжтой илэрхийлж чаддаг.	Яриагаа бүтцийн дагуу төлөвлөж, зураг болон үгээ сонгон бэлтгэн, бусдад ойлгомжтой илэрхийлж чаддаг.	Яриагаа бүтцийн дагуу төлөвлөж, зураг болон үгээ сонгон бэлтгэн, бусдад ойлгомжтой, цэгцтэй илэрхийлж чаддаг.
Хэлэлцүүлэг, ярилцлагын явцад бусдын яриаг таслахгүйгээр дуустал хүлээцтэй, ойлгож сонсдог.	Хэлэлцэх үедээ анхаарал нь зарим үед сарниж сонсдог.	Хэлэлцэх үедээ бусдад хүндэтгэлтэй хандаж, яриаг таслаагүй боловч хааяа анхаарал нь сарниж сонсдог.	Хэлэлцэх үедээ бусдад хүндэтгэлтэй хандаж, анхааралтай сонсож чаддаг.	Хэлэлцэх үедээ бусдад хүндэтгэлтэй хандаж, яриаг таслахгүйгээр дуустал хүлээцтэй сонсож чаддаг.
Шинэ баатар, шинэ орчин нэмж, зохиолын үйл явдлыг хэлэлцэхдээ бусдын үзэл бодлыг дүгнэдэг.	Зохиолын үйл явдлыг хэлэлцэхдээ шинэ санаа нэмээгүй ч бусдын үзэл бодлыг анхааралтай сонсдог.	Зохиолын үйл явдлыг хэлэлцэхдээ шинэ санаа нэмээгүй ч бусдын үзэл бодлыг анхааралтай, хүлээцтэй сонсдог.	Шинэ баатар, шинэ орчин нэмж, зохиолын үйл явдлыг хэлэлцэхдээ бусдын үзэл бодлыг асуулт асуун тодруулсны үндсэн дээр дүгнэдэг.	Шинэ баатар, шинэ орчин нэмж, зохиолын үйл явдлыг хэлэлцэхдээ бусдын үзэл бодлыг өөрийн үзэл бодолтой харьцуулан дүгнэдэг.

ТАВДУГААР БҮЛЭГ. V АНГИ

5.1. V АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Сурагч нь “зөв, хурдан, ойлгож” унших, уран унших, уншсанаа тайлбарлах, ялгах, харьцуулах, дүгнэх, санаа бодлоо тусган зохион найруулах, зөв бичгийн дүрмийг баримтлан бичих, эх хэлээрээ зөв, тодорхой ярих, санал бодлоо солилцон хэлэлцэх, баримттай илтгэх чадвар эзэмшиж, эх хэлээрээ бахархах иргэн төлөвшинө.

5.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ

5.2.1 Үнэлгээний нэгж 1. Уншсанаа ойлгох

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
5.1а. Эхэд ашигласан зарим үг, хэллэгийг сонгож, эхэд хэрэглэсэн учрыг тайлбарлан дүгнэх 5.1б. Нэг сэдэвтэй хоёр эхийн утгыг харьцуулах замаар эхийн агуулгыг ойлгосноо харуулах 5.1в. Уншсан жүжгийн зохиолын гол санааг тайлбарлах 5.1г. Уншсан эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгүүдийн утгын холбоо хамаарлыг тайлбарлах 5.1д. Эхээс хүншүүлсэн, хэтрүүлсэн дүрслэлийг тайлбарлах замаар үлгэрийн утгыг ойлгосноо харуулах 5.1е. Үлгэрт амьдралын бодит байдлыг тусгасан эс тусгасан шинжээр нь бодит байдал ба уран сэтгэмжийг ялгах 5.1ж. Уншсан эхийн баатруудын харилцан ярианаас тэдний зан чанарыг дүгнэх 5.1з. Захидлаас нэг сэдвийн талаар ялгаатай үзэл бодлыг харьцуулж дүгнэх	Сурагч эхийн утгыг ойлгож, зөв хурдан уншаад, уншсан зүйлээ тайлбарлаж, ялгаж, харьцуулж, дүгнэж чаддаг болно.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Сурагч эхийн утгыг ойлгож, зөв хурдан уншаад, уншсан зүйлээ тайлбарлаж, ялгаж, харьцуулж, дүгнэж чаддаг болно.	Сурагч 97-100%-ийн гүйцэтгэлтэй буюу “чадварлаг” түвшинд бүтэн үгээр, ярианы хурдаар, амьсгалаа тохируулан зөв, хурдан уншиж, агуулгыг бүрэн ойлгодог.
	Эхэд ашигласан зарим үг, хэллэгийг сонгож, эхэд хэрэглэсэн учрыг тайлбарлан дүгнэдэг.
	Эхийн гол санааг гарчиг болон зохиолчийн хэлэх гэсэн санаатай холбон тайлбарладаг болсон байна.
	Гол, төгсгөл хэсэг дэх үйл явдал ямар үйл явдлаас, баатрын ямар үйл хөдлөлөөс болж өрнөж байгааг оновчтой жишээ татан тайлбарладаг.
	Уншсан эх дэх хэтрүүлсэн (эсвэл хүншүүлсэн) дүрслэлийг тайлбарлахдаа оновчтой жишээ татан тайлбарладаг.
	Уншсан эхэд бодит байдлыг тусгасан эс тусгасан шинжээр нь бодит байдал ба уран сэтгэмжийг ялгадаг.
	Нэг сэдэвтэй хоёр эхийн утгыг бичигчийн зорилго, хэмжээ, үгийн сонголтоор нь харьцуулж уншдаг.
	Уншсан эхээс баатрын зан чанарын сайн, муу үйлийг нь харилцан ярианаас нь эргэцүүлэн, жишээн дээр үндэслэн дүгнэдэг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
97-100%-ийн гүйцэтгэлтэй буюу “чадварлаг” түвшинд бүтэн үгээр, ярианы хурдаар, амьсгалаа тохируулан зөв, хурдан уншиж, агуулгыг бүрэн ойлгодог.	90-ээс доош %-ийн гүйцэтгэлтэй буюу “хангалтгүй” түвшинд зарим үгийн авиа, үеийг буруу дуудан, эсвэл сольж, хурдан уншдаг, нийт агуулгын 70%-ийн утгыг ойлгодог.	90-96%-ийн гүйцэтгэлтэй буюу “хангалттай” түвшинд бүтэн үгээр, авиа, үеийг сольж, гээлгүй, ярианы хурдаар уншин, нийт агуулгын 80%-ийн утгыг ойлгодог.	90-96%-ийн гүйцэтгэлтэй буюу “хангалттай” түвшинд бүтэн үгээр, ярианы хурдаар, амьсгалаа тохируулан уншиж, агуулгыг бүрэн ойлгодог.	97-100%-ийн гүйцэтгэлтэй буюу “чадварлаг” түвшинд бүтэн үгээр, ярианы хурдаар, амьсгалаа тохируулан зөв, хурдан уншиж, агуулгыг бүрэн ойлгодог.
Эхэд ашигласан зарим үг, хэллэгийг сонгож, эхэд хэрэглэсэн учрыг тайлбарлан дүгнэдэг.	Сонгосон үгийн утгыг үгийн тайлбар толь бичиг ашиглан мэддэг.	Сонгосон үгийг тайлбарлан дүгнэхдээ ойр орчмын үг, өгүүлбэрийн утгаас таамагладаг.	Сонгосон үгийн утгыг “Тайлбар толь бичиг” ашиглан, зохиолчийн санаатай холбон тайлбарладаг.	Сонгосон үгийг зохиолчийн санаатай холбон яагаад хэрэглэснийг тайлбарлан дүгнэдэг.
Эхийн гол санааг гарчиг болон зохиолчийн хэлэх гэсэн санаатай холбон тайлбарладаг.	Гол санааг өөрийн үгээр тайлбарладаг.	Гол санааг илэрхийлсэн үг, өгүүлбэрийг сонгон тайлбарладаг.	Баатруудын хийсэн үйлдэл дээр тулгуурлан эхийн гол санааг тайлбарладаг.	Эхийн гол санааг гарчиг болон зохиолчийн хэлэх гэсэн санаатай холбон тайлбарладаг.
Гол, төгсгөл хэсэг дэх үйл явдал ямар үйл явдлаас, баатрын ямар үйл хөдлөлөөс болж өрнөж байгааг оновчтой жишээ татан тайлбарладаг.	Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг ялган таньдаг.	Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэг тус бүрийн утга санааг жишээгээр тайлбарладаг.	Гол, төгсгөл хэсэг дэх үйл явдал юунаас болж өрнөж байгааг “Ямар учраас, яагаад, юуны тулд” гэсэн асуулт хэрэглэн тайлбарладаг.	Гол, төгсгөл хэсэг дэх үйл явдал ямар үйл явдлаас, баатрын ямар үйл хөдлөлөөс болж өрнөж байгааг оновчтой жишээ татан тайлбарладаг.
Уншсан эх дэх хэтрүүлсэн (эсвэл хүншүүлсэн) дүрслэлийг тайлбарлахдаа оновчтой жишээ татан тайлбарладаг.	Эхээс хэмжээнээс нь хэтрүүлснийг /багасгаж, ихэсгэсэн хэсгийг/ болон амьтдын хэлсэн үгийг ялган таньдаг.	Хэмжээнээс нь хэтрүүлснийг болон хүний зан чанарыг амьтдын дүрээр гаргасныг жишээ татан тайлбарладаг.	Хэмжээнээс нь хэтрүүлснийг болон хүний зан чанарыг амьтдын дүрээр гаргасныг хэлсэн үгээс нь жишээ татан тайлбарладаг.	Хэмжээнээс нь хэтрүүлснийг болон хүний зан чанарыг амьтдын дүрээр гаргасныг хэлсэн үг, хийсэн үйлдлээс нь оновчтой жишээ татан тайлбарладаг.
Уншсан эхэд бодит байдлыг тусгасан эс тусгасан шинжээр нь бодит байдал ба уран сэтгэмжийг ялгадаг.	Эхээс бодит байдалд байдаггүй маш цөөн дүрслэлийг таньж ялгадаг.	Эхээс бодит байдалд байдаггүй зарим дүрслэлийг таньж ялгадаг.	Эхээс бодит байдалд байдаггүй ихэнх дүрслэлийг таньж ялгадаг.	Эхээс бодит байдалд байдаггүй, харж сонсоогүй бүх дүрслэлийг ялгадаг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Нэг сэдэвтэй хоёр эхийн утгыг бичигчийн зорилго, хэмжээ, үгийн сонголтоор нь харьцуулж уншдаг..	Нэг сэдэвтэй хоёр эхийн утгыг болон хэмжээгээр нь харьцуулдаг.	Нэг сэдэвтэй хоёр эхийн утгыг бичигчийн зорилго, хэмжээгээр нь харьцуулдаг.	Нэг сэдэвтэй хоёр эхийн утгыг бичигчийн зорилго, гол санаа, хэмжээгээр нь харьцуулдаг.	Нэг сэдэвтэй хоёр эхийн утгыг бичигчийн зорилго, гол санаа, хэмжээ, үгийн сонголтоор нь харьцуулдаг
Уншсан эхээс баатруудын зан чанарын сайн, муу үйлийг нь харилцан ярианаас нь эргэцүүлэн, жишээн дээр үндэслэн дүгнэдэг	Баатруудын харилцан ярианаас сайн, муу үйл хийснийг ялгадаг.	Баатруудын зан араншин, сэтгэл санааны байдлыг, тэдний хэлж буй үгээс дүгнэдэг.	Баатруудын зан чанарын сайн, муу үйлийг нь харилцан ярианаас нь эргэцүүлэн дүгнэдэг.	Баатруудын зан чанарын сайн, муу үйлийг нь харилцан ярианаас нь эргэцүүлэн, жишээн дээр үндэслэн дүгнэдэг.

5.2.2. Үнэлгээний нэгж 2. Уншсанаа бүтээлчээр ойлгох

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
5.1к. Үйл явдал хаана, хэзээ өрнөж байгааг ургуулан бодож төсөөлөх 5.1л. Онцсогын далд утгыг үндэслэлтэй таамаглах	Зохиолыг унших явцдаа төсөөлж, таамаглах чадвараа харуулна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Зохиолыг унших явцдаа төсөөлж, таамаглах чадвараа харуулна.	Үйл явдлыг өрнүүлэхдээ газар орон, цаг хугацааг оновчтой үгээр илэрхийлэн, ургуулан бодож, өөрийн оюун дүгнэлтээр төсөөлдөг.
	Онцсогын далд утга буюу адилтгагдаж байгаа юмс үзэгдэл, адилтгаж байгаа юмсын ижил төстэй шинжийг харьцуулсны үндсэн дээр таамагладаг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Үйл явдлыг өрнүүлэхдээ газар орон, цаг хугацааг оновчтой үгээр илэрхийлэн, ургуулан бодож, өөрийн оюун дүгнэлтээр төсөөлдөг.	Зургийн тусламжтайгаар газар орныг ургуулан бодож, өөрийн оюун дүгнэлтээр төсөөлдөг.	Үйл явдлыг өрнүүлэхдээ багшийн тусламжтайгаар газар орон, бодит цаг хугацааг ургуулан бодож, өөрийн оюун дүгнэлтээр төсөөлдөг.	Ямар, яг юу шиг гэсэн асуултаар дэлгэрүүлэн, газар орон, бодит цаг хугацааг ургуулан бодож, өөрийн оюун дүгнэлтээр төсөөлдөг.	Үйл явдлыг өрнүүлэхдээ газар орон, цаг хугацааг оновчтой үгээр илэрхийлэн, ургуулан бодож, өөрийн оюун дүгнэлтээр төсөөлдөг.

Онъсогын далд утга буюу адилтгагдаж байгаа юмс үзэгдэл, адилтгаж байгаа юмсын ижил төстэй шинжийг харьцуулсны үндсэн дээр таамагладаг.	Онъсогын далд утга буюу адилтгагдаж байгаа юмс үзэгдлийг өөрийнхөөрөө ургуулан боддог.	Онъсогын далд утга буюу адилтгагдаж байгаа юмс үзэгдлийн шинжийг тоочдог.	Онъсогын далд утга буюу адилтгагдаж байгаа юмс үзэгдлийн шинж дээр үндэслэн таамагладаг.	Онъсогын далд утга буюу адилтгагдаж байгаа юмс үзэгдэл, адилтгаж байгаа юмсын ижил төстэй шинжийг харьцуулсны үндсэн дээр таамагладаг.
--	--	---	--	--

Тайлбар:

“5.1л. Онъсогын далд утгыг үндэслэлтэй таамаглах” суралцахуйн зорилт дахь онъсогын далд утга гэдэг нь онъсоголж тааж буй зүйлийг хэлнэ. Өөрөөр хэлбэл онъсогын хариу юм. Жишээ нь, “түнтгэр өвгөн, түмэн жадтай” гэсэн онъсогын далд утга буюу онъсоголж байгаа зүйл нь зараа юм. Сурагчид яагаад зараа болохыг таамаглахдаа яагаад өвгөн, бүр түнтгэр өвгөн гэснийг зараа өвгөн хоёрын адил төстэй зүйл дээр (бөгтийж явдаг, удаан явдаг гэх мэт) үндэслэн харьцуулан таамаглах учиртай. Зарааны үсийг яагаад жад, түмэн жад гэснийг үс, жад хоёрын адил төстэй шинжийг харьцуулан бодож таамаглана. Тиймээс шалгуур боловсруулахдаа зараа буюу далд утгыг нь “адилтгагдаж байгаа зүйл” гэж, өвгөн, жад хоёрыг “адилтгаж байгаа зүйл” гэж нэршүүлсэн болно.

5.2.3 Үнэлгээний нэгж 3. Зөв бичих

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
5.2а. Залгавар залгахад эгшиг гээгдэх, гээгдэхгүй тохиолдлыг мэдэж, бүлэглэх, тайлбарлах	Зөв бичих дүрмийг мэдэж, зохион найруулж бичихдээ алдаагүй зөв бичиж сурна.
5.2б. Үйл үг бүтээх “-л” дагаврын дүрмийг мэдэж, зөв бичих	

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Зөв бичих дүрмийг мэдэж, зохион найруулж бичихдээ алдаагүй зөв бичиж сурна.	Үйл үг бүтээх “-л” дагаврын дүрмийн дагуу зөв бичиж сурна.
	Эгшиг гээгдэх, гээгдэхгүй тохиолдлыг мэдэж, дүрмийн дагуу зөв бичиж сурна.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Үйл үг бүтээх “-л” дагаврын дүрмийн дагуу зөв бичиж сурна.	Үйл үг бүтээх “-л” дагаврын дүрмийг мэддэг.	Үйл үг бүтээх “-л” дагаврын дүрмийн зүй тогтлыг жишээн дээр тайлбарлаж чаддаг.	Үйл үг бүтээх “-л” дагаврын дүрмийн алдаатай үгийг таньж, засаж чаддаг.	Үйл үг бүтээх “-л” дагаврын дүрмийн дагуу зөв бичдэг.
Эгшиг гээгдэх, гээгдэхгүй тохиолдлыг мэдэж, дүрмийн дагуу зөв бичиж сурна.	Эгшиг гээгдэх, гээгдэхгүй тохиолдлыг мэддэг.	Эгшиг гээгдэх, гээгдэхгүй дүрмийн зүй тогтлыг жишээн дээр тайлбарлаж чаддаг.	Эгшиг гээгдэх, гээгдэхгүй дүрмийн алдаатай үгийг таньж, засаж чаддаг.	Эгшиг гээгдэх, гээгдэхгүй дүрмийн дагуу зөв бичдэг.

5.2.4. Үнэлгээний нэгж 4. Зохион найруулж бичих

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
5.2в. Эхийн үйл явдлын орчныг өөрчлөн, богино өгүүллэг зохион бичих 5.2г. Зохиолын санааг нэгтгэн дүгнэн товчилж бичих 5.2д. Бусдын үзэл бодлыг дэмжсэн, эсвэл эсэргүүцсэн утгатай захидал бичих 5.2е. Өдрийн тэмдэглэлээ бичихдээ сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэх 5.2ж. Чухал, шинэ үйл явдлыг баримтаар нотлон, бүтцийн дагуу мэдээ бичих 5.2з. Бусдын анхаарлыг таттал ятгаж бичих 5.2и. Жүжигт баатруудын харилцан яриаг нэмэн бичих 5.2к. Адил төстэй шинжийг харьцуулан, утгыг далдлан оньсого зохион бичих 5.2л. Баримт, зураг, график хэрэглэн баталгаа нотолгоо гарган санаагаа илэрхийлж бичих 5.2м. Өгсөн бүтцийн дагуу үлгэр зохиох	Сурагч өгөгдсөн бүтэц, зааврын дагуу эх зохиож, товчилж, ятгаж, илэрхийлж, найруулан хурдтай бичиж чаддаг болсон байна. (богино, өгүүллэг, үлгэр, захидал, харилцан яриа, мэдээ, оньсого)

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Сурагч өгөгдсөн бүтэц, зааврын дагуу эх зохиож, товчилж, ятгаж, илэрхийлж, найруулан хурдтай бичиж чаддаг болсон байна. /богино, өгүүллэг, үлгэр, захидал, мэдээ, оньсого/	Зохиолын агуулгыг товчлохдоо гол гол санааг хураангуйлан, цөөн үгээр ойлгомжтой, зөв бичгийн дүрмийн алдаагүй бичиж чаддаг.
	Баримт, зураг, график хэрэглэн баталгаа нотолгоо гарган санаагаа илэрхийлэхдээ ойлгомжтой, утгын уялдаа холбоотой, зөв бичгийн дүрмийн алдаагүй бичиж чаддаг.
	Бусдын үзэл бодлыг дэмжсэн, эсвэл эсэргүүцсэн үг хэрэглэн, эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй, цогцолборуудыг догол мөрөөр зааглан, утгын уялдаа холбоотой, зөв бичгийн дүрмийн алдаагүй бичиж чаддаг.
	Бусдын анхаарлыг татсан үг, баримт, зураг хэрэглэн ятгаж, ойлгомжтой бичдэг.
	Чухал, шинэ үйл явдлыг бичихдээ эхлэл хэсэгт хэн, хэзээ, хаана, юу болсныг товч, гол хэсэгтээ баримтаар дэлгэрүүлэн, учир шалтгаан, нөхцөл байдлыг тодруулан, төгсгөл хэсэгтээ мэдээ бичсэн хүний нэрийг тус тус алдаагүй, зөв, ойлгомжтой илэрхийлдэг.
	Үлгэр зохиохдоо эхлэл хэсэгт дүр, нөхцөл байдал, орчноо танилцуулан, гол хэсэгтээ баатруудад тохиолдсон явдал, бэрхшээл, боломжийг өрнүүлэн, төгсгөл хэсэгтээ асуудлыг шийдвэрлэсэн санаагаа ойлгомжтой, цогцолборуудыг догол мөрөөр зааглан, утгын уялдаа холбоотой, алдаагүй, зөв, хичээнгүй илэрхийлдэг.
	Өөрт тохиолдсон явдлаа сэтгэгдэл, мэдрэмжээр дэлгэрүүлэн өдрийн тэмдэглэл зохиохдоо эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй, цогцолборуудыг догол мөрөөр зааглан, утгын уялдаа холбоотой, ойлгомжтой, алдаагүй, зөв, хичээнгүй хурдтай бичдэг.
	Таалгах гэж байгаа эд юмсынхаа шинжтэй адил төстэй зүйлийг харьцуулан, орлуулан оньсого зохиохдоо ойлгомжтой, алдаагүй, зөв, хичээнгүй бичдэг.
	Жүжигт баатруудын харилцан яриаг нэмэн зохиохдоо зохиолын санааны дагуу яриаг өрнүүлэн сонирхолтой, үнэмшилтэй, ойлгомжтой, алдаагүй, хашилт, хаалтыг зөв хэрэглэн, хичээнгүй бичдэг.
	Эхийн үйл явдлын орчныг өөрчлөн богино өгүүллэг зохиохдоо орон байр, улирал, цаг агаар, цаг хугацааг тусган ойлгомжтой, утгын уялдаа холбоотой, алдаагүй, зөв, хичээнгүй, цогцолборуудыг догол мөрөөр зааглан, хурдтай бичиж илэрхийлдэг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Зохиолын агуулгыг товчлохдоо гол гол санааг хураангуйлан, цөөн үгээр ойлгомжтой, зөв бичгийн дүрмийн алдаагүй бичиж чаддаг.	Зохиолын санааг дутуу ойлгож, үйл явдлыг дэс дараалан, ойлгомжтой бичдэг.	Багшийн зааврын дагуу зохиолын гол гол санааг хураангуйлан бичиж чаддаг.	Зохиолын агуулгыг товчлохдоо гол гол санааг хураангуйлан, ойлгомжтой, утгын уялдаа холбоотой, алдаагүй бичиж чаддаг.	Зохиолын агуулгыг товчлохдоо гол гол санааг хураангуйлан, цөөн үгээр ойлгомжтой, зөв бичгийн дүрмийн алдаагүй бичиж чаддаг.
Баримт, зураг, график хэрэглэн баталгаа нотолгоо гарган санаагаа илэрхийлэхдээ ойлгомжтой, утгын уялдаа холбоотой, зөв бичгийн дүрмийн алдаагүй бичиж чаддаг.	Уншсан зүйлийн талаар санаагаа илэрхийлэхдээ ойлгомжтой бичиж чаддаг.	Баримт (зураг, график гэх мэт) хэрэглэн санаагаа илэрхийлэхдээ ойлгомжтой бичиж чаддаг.	Баримт (зураг, график гэх мэт) хэрэглэн баталгаа нотолгоо гарган санаагаа илэрхийлэхдээ ойлгомжтой, зөв бичгийн дүрмийн алдаагүй бичиж чаддаг.	Баримт (зураг, график гэх мэт) хэрэглэн баталгаа нотолгоо гарган санаагаа илэрхийлэхдээ ойлгомжтой, утгын уялдаа холбоотой, зөв бичгийн дүрмийн алдаагүй бичиж чаддаг.
Бусдын үзэл бодлыг дэмжсэн, эсвэл эсэргүүцсэн утгатай захидлыг эхлэл, гол, төгсгөл хэсэг дэх цогцолборуудыг догол мөрөөр зааглан, утгын уялдаа холбоотой, ойлгомжтой бичдэг. (5.2д), (5.4г)	Дэмжсэн, эсвэл эсэргүүцсэн үг хэрэглэн захидал бичдэг.	Дэмжсэн, эсвэл эсэргүүцсэн үг хэрэглэн, эхлэл, гол, төгсгөл хэсгээр санаагаа зааглан бичдэг.	Дэмжсэн, эсвэл эсэргүүцсэн үг хэрэглэн, эхлэл, гол, төгсгөл хэсгээр санаагаа зааглан утгын уялдаа холбоотой, алдаагүй бичдэг.	Бусдын үзэл бодлыг дэмжсэн, эсвэл эсэргүүцсэн үг хэрэглэн, эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй, цогцолборуудыг догол мөрөөр зааглан, утгын уялдаа холбоотой, зөв бичгийн дүрмийн алдаагүй бичиж чаддаг.
Бусдын анхаарлыг татсан үг хэллэг, баримт, зураг хэрэглэн ятгаж, бичиж чаддаг.	Бусдын анхаарлыг татсан зураг хэрэглэн ятгаж бичдэг.	Бусдын анхаарлыг татсан зураг хэрэглэн ятгаж, ойлгомжтой бичдэг.	Бусдын анхаарлыг татсан баримт, зураг хэрэглэн ятгаж, ойлгомжтой бичдэг.	Бусдын анхаарлыг татсан үг, баримт, зураг хэрэглэн ятгаж, ойлгомжтой бичдэг.
Чухал, шинэ үйл явдлыг бичихдээ эхлэл хэсэгт хэн, хэзээ, хаана, юу болсныг товч, гол хэсэгтээ баримтаар дэлгэрүүлэн, учир шалтгаан, нөхцөл байдлыг тодруулан, төгсгөл хэсэгтээ мэдээ бичсэн хүний нэрийг тус тус алдаагүй, ойлгомжтой илэрхийлдэг.	Чухал, шинэ үйл явдлыг тоочин дарааллуулан бичдэг.	Чухал, шинэ үйл явдлыг бичихдээ хэн, хэзээ, хаана, юу болсныг тоочиж, алдаагүй, ойлгомжтой илэрхийлдэг.	Чухал, шинэ үйл явдлыг бичихдээ эхлэл хэсэгт хэн, хэзээ, хаана, юу болсныг товч, гол хэсэгтээ баримтыг дурдан, төгсгөл хэсэгтээ мэдээ бичсэн хүний нэрийг тус тус алдаагүй, зөв, ойлгомжтой илэрхийлдэг.	Чухал, шинэ үйл явдлыг бичихдээ эхлэл хэсэгт хэн, хэзээ, хаана, юу болсныг товч, гол хэсэгтээ баримтаар дэлгэрүүлэн, учир шалтгаан, нөхцөл байдлыг тодруулан, төгсгөл хэсэгтээ мэдээ бичсэн хүний нэрийг тус тус алдаагүй, зөв, ойлгомжтой илэрхийлдэг.
Үлгэр зохиохдоо эхлэл хэсэгт дүр, орчноо танилцуулан, гол хэсэгтээ баатруудад тохиолдсон явдал, бэрхшээл, боломжийг өрнүүлэн, төгсгөл хэсэгтээ асуудлыг шийдвэрлэсэн санаагаа алдаагүй, цогцолборуудыг догол мөрөөр зааглан, утгын уялдаа холбоотой, ойлгомжтой, хичээнгүй илэрхийлдэг.	Үлгэр зохиохдоо үйл явдлыг дарааллуулан тоочиж, ойлгомжтой, хичээнгүй илэрхийлдэг.	Үлгэр зохиохдоо үйл явдлыг дарааллуулан тоочиж, ойлгомжтой, алдаагүй зөв, бичиж илэрхийлдэг.	Үлгэр зохиохдоо эхлэл хэсэгт дүр, орчноо танилцуулан, гол хэсэгтээ баатруудад тохиолдсон явдал, бэрхшээл, боломжийг өрнүүлэн, төгсгөл хэсэгтээ асуудлыг шийдвэрлэсэн гэсэн санаагаа ойлгомжтой, алдаагүй, хичээнгүй илэрхийлдэг.	Үлгэр зохиохдоо эхлэл хэсэгт дүр, орчноо танилцуулан, гол хэсэгтээ баатруудад тохиолдсон явдал, бэрхшээл, боломжийг өрнүүлэн, төгсгөл хэсэгтээ уншигчдад хэлэх гэсэн санаагаа алдаагүй, цогцолборуудыг догол мөрөөр зааглан, утгын уялдаа холбоотой, ойлгомжтой, хичээнгүй илэрхийлдэг.

Өөрт тохиолдсон явдлаа сэтгэгдэл, мэдрэмжээр дэлгэрүүлэн өдрийн тэмдэглэл зохиохдоо эхлэл, гол, төгсгөл хэсэг дэх цогцолборуудыг догол мөрөөр зааглан, утгын уялдаа холбоотой, ойлгомжтой, алдаагүй, зөв, хичээнгүй бичиж чаддаг.	Өөрт тохиолдсон явдлаа бичихдээ утгын уялдаа холбоотой, ойлгомжтой бичдэг.	Өөрт тохиолдсон явдлаа сэтгэгдлээр дэлгэрүүлэн өдрийн тэмдэглэл зохиохдоо утгын уялдаа холбоотой, ойлгомжтой, алдаагүй, зөв, хичээнгүй бичдэг.	Өөрт тохиолдсон явдлаа сэтгэгдэл, мэдрэмжээр дэлгэрүүлэн өдрийн тэмдэглэл зохиохдоо эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй, утгын уялдаа холбоотой, ойлгомжтой, алдаагүй, зөв, хичээнгүй, хурдтай бичдэг.	Өөрт тохиолдсон явдлаа сэтгэгдэл, мэдрэмжээр дэлгэрүүлэн өдрийн тэмдэглэл зохиохдоо эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй, цогцолборуудыг догол мөрөөр зааглан, утгын уялдаа холбоотой, ойлгомжтой, алдаагүй, зөв, хичээнгүй, хурдтай бичдэг.
Таалгах гэж байгаа эд юмсынхаа шинжтэй адил төстэй зүйлийг харьцуулан, оньсого зохиохдоо ойлгомжтой, алдаагүй, зөв, хичээнгүй бичиж чаддаг. (5.2к)	Таалгах гэж байгаа эд юмсынхаа шинжийг тоочин оньсого зохиохдоо ойлгомжтой бичдэг.	Таалгах гэж байгаа эд юмсынхаа шинжийг тоочин оньсого зохиохдоо ойлгомжтой, алдаагүй бичдэг.	Таалгах гэж байгаа эд юмсынхаа шинжтэй адил төстэй зүйлийг харьцуулан, орлуулан оньсого зохиохдоо ойлгомжтой, хичээнгүй бичдэг.	Таалгах гэж байгаа эд юмсынхаа шинжтэй адил төстэй зүйлийг харьцуулан, орлуулан оньсого зохиохдоо ойлгомжтой, алдаагүй, зөв, хичээнгүй бичдэг
Жүжигт баатруудын харилцан яриаг нэмэн зохиохдоо зохиолын санааны дагуу яриаг өрнүүлэн сонирхолтой, үнэмшилтэй, ойлгомжтой, алдаагүй, хичээнгүй бичсэн байна. (5.2и), (5.4а)	Жүжигт нэг баатрын хэлэх үгийг нэмж зохиохдоо ойлгомжтой, хичээнгүй бичдэг.	Жүжигт баатруудын харилцан яриаг нэмэн зохиохдоо ойлгомжтой, алдаагүй бичдэг	Жүжигт баатруудын харилцан яриаг нэмэн зохиохдоо зохиолын санааны дагуу яриаг өрнүүлэн, ойлгомжтой, алдаагүй хичээнгүй бичдэг.	Жүжигт баатруудын харилцан яриаг нэмэн зохиохдоо зохиолын санааны дагуу яриаг өрнүүлэн сонирхолтой, үнэмшилтэй, ойлгомжтой, алдаагүй, хашилт, хаалтыг зөв хэрэглэн, хичээнгүй бичдэг
Эхийн үйл явдлын орчныг өөрчлөн богино өгүүллэг зохиохдоо орон байр, улирал, цаг агаар, цаг хугацааг тусган ойлгомжтой, утгын уялдаа холбоотой, алдаагүй, зөв, хичээнгүй, цогцолборуудыг догол мөрөөр зааглан илэрхийлдэг (5.2в), (5.2и), (5.4г)	Эхийн үйл явдлын орчныг өөрчлөн богино өгүүллэг зохиохдоо зөвхөн хаана, хэзээ болж байгааг тусган ойлгомжтой, хичээнгүй бичиж илэрхийлдэг.	Эхийн үйл явдлын орчныг өөрчлөн богино өгүүллэг зохиохдоо орон байр, улирал, цаг хугацааг тусган ойлгомжтой, хичээнгүй бичиж илэрхийлдэг.	Эхийн үйл явдлын орчныг өөрчлөн богино өгүүллэг зохиохдоо орон байр, улирал, цаг агаар, цаг хугацааг тусган ойлгомжтой, алдаагүй, зөв, хичээнгүй, цогцолборуудыг догол мөрөөр зааглан, хурдтай бичиж илэрхийлдэг.	Эхийн үйл явдлын орчныг өөрчлөн богино өгүүллэг зохиохдоо орон байр, улирал, цаг агаар, цаг хугацааг тусган ойлгомжтой, утгын уялдаа холбоотой, алдаагүй, зөв, хичээнгүй, цогцолборуудыг догол мөрөөр зааглан, хурдтай бичиж илэрхийлдэг.

Тайлбар:

“5.2л. Баримт, зураг, график хэрэглэн баталгаа нотолгоо гарган санаагаа илэрхийлж бичих” суралцахуйн зорилтын хүрэн дэх баримт гэснийг дараах байдлаар ойлгож болно.

- Тоон баримт
- Цаг хугацааны баримт
- Үзсэн хүүхэдэйн кино, уншсан үлгэр болон бусад зохиолын баатрын хэлсэн үг, номын тэмдэглэл
- Өөрт нь тохиолдсон бодитой явдал, адал явдал
- Хэлц үг, зүйр цэцэн үг зэргийг баримт хэмээн ойлгож, сурагчид санаагаа батлахдаа хэрэглэж бичиж болно.

5.2.5. Үнэлгээний нэгж 5. Бусдыг ойлгон сонсох, санаа бодлоо илэрхийлэн харилцах

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
5.3а. Тодорхой сэдвийн хүрээнд хэд хэдэн зүйлийг харьцуулж, дүгнэх	Сурагч хэлэлцэх, илтгэх үедээ үзэл бодлоо илэрхийлж, бусдын санаа бодлыг харьцуулж дүгнэж чаддаг болсон байна.
5.3б. Хэлэлцэх, илтгэх үедээ сонссон зүйлийн голыг олж, зөв сонссон гэдгээ илэрхийлэх 5.3в. Хэлэлцэх, илтгэх үедээ үзэл бодлоо баримт хэрэглэн товч тодорхой оновчтой илэрхийлэх	Хэлэлцэх үедээ сонссон зүйлийн голыг олж, зөв сонссон гэдгээ илэрхийлж сурсан байна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Сурагч хэлэлцэх, илтгэх үедээ үзэл бодлоо илэрхийлж, бусдын санаа бодлыг харьцуулж дүгнэж чаддаг болсон байна.	Бусдын санаа бодлыг өөрийн үзэл бодолтой харьцуулж дүгнэж сонсдог. Хэлэлцэх, илтгэх үед үзэл бодлоо илэрхийлэхдээ зураг, бүдүүвч схем, хүснэгтэн мэдээлэл зэргийг хэрэглэн, ойлгомжтой, товч тодорхой оновчтой ярьдаг.
Хэлэлцэх үедээ сонссон зүйлийн голыг олж, зөв сонссон гэдгээ илэрхийлж сурсан байна.	Сонссон зүйлийнхээ гол санааг тулгуур бичиглэл, товч өгүүлбэрээр илэрхийлж, зөв сонссон гэдгээ харуулж чаддаг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Бусдын санаа бодлыг өөрийн үзэл бодолтой харьцуулж дүгнэж сонсдог.	Бусдын санаа бодлыг анхааралтай, хүлээцтэй сонсдог.	Бусдын хэлсэн санааг тунгаан бодож, эргэцүүлж, ойлгож сонсдог.	Бусдын санаа бодлуудыг харьцуулж сонсдог.	Бусдын санаа бодлыг өөрийн үзэл бодолтой харьцуулж дүгнэж сонсдог.
Хэлэлцэх, илтгэх үед үзэл бодлоо илэрхийлэхдээ зураг, бүдүүвч схем, хүснэгтэн мэдээлэл зэргийг хэрэглэн, ойлгомжтой, товч тодорхой оновчтой ярьдаг.	Хэлэлцэх, илтгэх үедээ үзэл бодлоо ойлгомжтой илэрхийлдэг.	Хэлэлцэх, илтгэх үедээ үзэл бодлоо ойлгомжтой, товч, тодорхой илэрхийлдэг.	Хэлэлцэх, илтгэх үедээ үзэл бодлоо зураг, бүдүүвч схем, хүснэгтэн мэдээлэл зэргийг хэрэглэн, ойлгомжтой илэрхийлдэг.	Хэлэлцэх, илтгэх үед үзэл бодлоо илэрхийлэхдээ зураг, бүдүүвч схем, хүснэгтэн мэдээлэл зэргийг хэрэглэн, ойлгомжтой, товч тодорхой оновчтой ярьдаг.
Сонссон зүйлийнхээ гол санааг тулгуур бичиглэл, товч өгүүлбэрээр илэрхийлж, зөв сонссон гэдгээ харуулж чаддаг.	Бусадтай харилцахдаа асуулт асууж, санаа бодлыг нь ойлгон харилцдаг.	Сонссон зүйлийнхээ гол санааг тайлбарлан, зөв сонссон гэдгээ харуулж чаддаг.	Сонссон зүйлийнхээ гол санааг товч өгүүлбэрээр илэрхийлж, зөв сонссон гэдгээ харуулж чаддаг.	Сонссон зүйлийнхээ гол санааг тулгуур бичиглэл, товч өгүүлбэрээр илэрхийлж, зөв сонссон гэдгээ харуулж чаддаг.

“ЕБС-ийн Бага боловсролын хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур”-ыг боловсруулсан ажлын хэсэг:

Математик

А.Гантуул	МУБИС, БС-ийн багш, доктор (Ph.D)
Б.Болортуяа	“Хаан Эрдэм” сургуулийн сургалтын менежер
О.Наранчимэг	“Шинэ Монгол Харүмафүжи” сургуулийн багш, тэргүүлэх
Д.Мөнх-Өлзий	“Сингафур” сургуулийн багш, заах аргач

Монгол хэл

Ш.Оюунцэцэг	БМДИ-ийн зөвлөх багш
П.Одсүрэн	БМДИ-ийн арга зүйч, доктор (Ph.D.)
Д.Ганчимэг	БХ, Бага боловсролын хөтөлбөрийн судалгаа хариуцсан мэргэжилтэн, магистр

Хүн ба Орчин, Хүн ба Байгаль

Э.Даваахүү	“Суралцахуйн баясгалан” сургалт, судалгааны төвийн захирал, магистр
Д.Чанцалдулам	“Шинэ Монгол Харүмафүжи” сургуулийн багш
З.Лхагвадулам	24 дүгээр сургуулийн багш

Хүн нийгэм

У.Туяа	Боловсролын хүрээлэнгийн секторын эрхлэгч, доктор (Ph.D)
Д.Янжинжав	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, магистр

Дүрслэх урлаг, технологи

С.Отгонтуяа	Боловсролын хүрээлэн, ЭША, магистр
Ч.Алтанчимэг	20 дугаар сургуулийн багш, зөвлөх
Б.Мөнхтуяа	“Амгалан” цогцолбор сургуулийн багш, магистр
С.Цолмон	“Шинэ эхлэл” сургуулийн багш, зөвлөх
Ж.Энхбаатар	“Шинэ зуун билэг” сургуулийн багш, зөвлөх

Эрүүл мэнд

Ч.Байгалмаа	МУБИС, БСС-ийн багш, доктор (Ph.D)
Б.Болорцэцэг	Нийслэлийн ЕБ-ын 1 дүгээр сургуулийн багш, зөвлөх
Ц.Дийдэрмаа	Нийслэлийн ЕБ-ын 47 дугаар сургуулийн багш, зөвлөх

Хөндлөнгийн шинжээч:

Д.Түмэнбаяр	МУИС. ШУС-ийн математикийн тэнхимийн багш, доктор (Ph.D)
Ө.Цэндсүрэн	Монгол улсын гавьяат багш
С.Түмэндэлгэр	МУБИС, НХУС, Нийгмийн ухааны тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор
Д.Хөхөө	МУБИС-ийн ДУТС-ийн зөвлөх багш, доктор (Ph.D)
Э.Мөнгөнтулга	МУБИС-ийн МБУС-ийн багш

Техникийн редактор:

Г. Дэлгэрмаа	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, доктор (Ph.D)
Т.Отгон-Эрдэнэ	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн

Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:

Э.Сансартуяа	"Хас дизайн пресс" ХХК-ийн дизайнер
Л.Алтансүх	Боловсролын үнэлгээний төвийн ахлах мэргэжилтэн

Энэхүү номын цахим хувилбар нь www.eec.mn вэб сайтад байршсан болно.



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо
Энхтайваны өргөн чөлөө, Арслантай гүүр
“ОЮУНЫ УНДРАА” группийн байр

Утас: 70119498, 70118485
И-мэйл: info@eecs.mn